

Монгол Ардын Хувьсгалт Нам ардчилал, геополитикийн шахаанд орсон нь

Доктор Удо Б. Баркманн
МУИС-ийн зочин профессор, ШУА-ийн ОУСХ,
Монголын "Герман Судлал" Төвийн гүйцэтгэх захирал

1996 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн сонгууль – МАХН-ын хувьд сүйрэл байв уу, шинэтгэлийн түлхэц болов уу?

1996 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн сонгууль нь Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын төдийгүй, Монгол орон дахь ардчиллын хувьд ч гэсэн том шалгуур болсон гэдгийг тусад нь тайлбарлах шаардлагагүй болов уу. Сонгуулийн өмнөх улс төрийн туйлшралын уур амьсгалыг сөрөг хүчний зүгээс эрх мэдэл, засаглалын тогтолцооны өөрчлөлтийг хэрэгжүүлэхээр зэхэж байсны баталгаа гэж үзэж болохоор байлаа. 1992 оны УИХ-ын сонгуульд 11 субъект (нам, намын бүлэглэлүүд, бие дааж нэр дэвшигчдийн бүлэг г.м.) оролцож байсан бол энэ удаад сонгуулийн 8 субъект сонгогчдын саналыг авахаар улайрч байв. Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН) нь бусад жижиг намтай нэгдэж Ардчилсан Холбоо (АХ) эвслийг байгуулж, үүнийг өмнө нь Ерөнхийлөгчийн тамгын газарт ажиллаж байсан М.Энхсайхан удирдсан байлаа. Энэ эвсэл нь хүмүүст сонгуулийн бүрэн дүүрэн, дэлгэрэнгүй, нийгмийн амьдралын бүх хүрээг хамрах хөтөлбөр буюу МУАН, Монголын Социал Демократ Нам (МСДН)-ын Ардчилсан Холбооны эвслийн гэрээ гэгчийг танилцуулж, түүгээрээ төрийг өөрчлөн шинэчлэх, Засгийн газар, захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод болгохоо амласан юм.

АХ нь сонгуульд нилээд сайтар бэлтгэж байхад МАХН-ын удирдлага сонгуулийн бэлтгэл ажлыг харьцангуй тайвнаар эхлүүлээ. 1994 оноос эдийн засаг тогтворжиж эхэлсэн нь МАХН-аас эдийн засгийг эрүүлжүүлэх зөв бодлого сонгож чадсаныг батлах мэт. Харин тогтворжих энэхүү үе хамгийн доод түвшинд (1994 онд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний өсөлт 2.3 хувь, 1995 онд 6.3 хувь) хэрэгжиж, зарим талаар зөвхөн гадаадын зээл тусламжийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэнийг сонгогчдод дуулгаагүй билээ. Намын удирдлага нь гишүүдийнхээ идэвхи санаачилга, өөрийн зохион байгуулалт, боломжид тулгуурлан "шинэ" намуудыг сонгуульд хялбархан ялна гэдэгтээ огтхон ч эргэлзэхгүй байв. МАХН нь дадсан ёсоороо улс орон даяар 16.000 орчим

сонгуулийн туслахыг сонгуулийн бэлтгэл ажилд дайчилжээ. Сонгуулийн 75 хороодод ажиллах нийт 662 хүнээс МАХН дангаараа 53.3 хувийг, харин АХ дөнгөж 22.0¹ хувийг бүрдүүлж байв. Сонгуулийн ухуулгын ажилд МАХН 37.578.600 төгрөг зарцуулсан бол АХ нь 57.388.410 төгрөгийг энэ зорилгод зарцуулжээ. МАХН-аас сонгуулийн кампанит ажилд оролцогчдыг дөнгөж 3.158.900 төгрөг зарцуулж урамшуулсан бол АХ-ноос энэ ажилд 16.300.235 төгрөгийг зориулжээ. Нам тус бүрийн гишүүдийн тоог (МАХН 86.000, МҮАН 40.000, МСДН 28.000) сонгуулийн кампанит ажилд намын хөрөнгөөс зарцуулсан үнийн дүнтэй харьцуулж үзсэн нь МҮАН, МСДН-уудын санхүүгийн эх сурвалжийн талаар тодруулахад хүргэсэн юм.

Сонгуулийн кампанит ажлын санхүүгийн эх сурвалж

| Орлого | АХ | МАХН |
|---|------------|------------|
| Өөрийн хөрөнгө | 80.461.500 | 37.975.700 |
| Олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж | 8.900.000 | 24.645.100 |
| Иргэдийн хандив | байхгүй | 6.215.500 |
| Бусад | 77.981 | байхгүй |
| Нийт орлого | 89.439.481 | 68.896.300 |
| Нийт зарлага | 89.439.481 | 68.896.300 |

Харин сонгууль МАХН-ын удирдлагын бодож, төсөөлж байснаас огт өөрөөр болж өнгөрлөө. 1996 оны 6 дугаар сарын 30-ны сонгуульд Японоос дөрөв, АНУ-аас долоо, ОХУ-аас ажиглагчдаа илгээсэн агаад албан ёсны дүнг үзвэл, санал хураалтын дүн дараах байдалтай гарч байна.

| Нам | Авсан санал | Хувиар |
|-----------|-------------|--------|
| МАХН | 408977 | 40,6 % |
| МҮАН | 306964 | 30,5 % |
| МСДН | 134734 | 13,4 % |
| Бусад нам | 124500 | 12,4 % |
| Бие даагч | 31072 | 3,1 % |

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа саналын олонхийн зарчмаар АХ 46.7, МАХН 40.6 хувийг өөртөө төвлөрүүлж чадсан байна. Иймээс УИХ-ын суудал АХ-ны талд ашигтайгаар хуваарилагдаж АХ 50 мандат буюу нийт суудлын 65.8 хувь, МАХН 25 мандат буюу суудлын 32.5 хувийг

¹ ОХУ, АНУ. Японоос ажиглагч ирнэ, Засгийн газрын мэдээ, 1996.06.07

авсан байна. Монголын Уламжлалын Нэгдсэн Нам (МУНН) нэг мандат авчээ. Хэдийгээр МАХН сонгуульд ялагдсан ч хориг тавих цөөнхийн боломж нь нээлттэй үлдсэн бөгөөд улмаар парламентын шийдвэрийг саатуулах боломжтой, чадвартай гэдгээ сүүлд батлан харуулсан билээ. МАХН сонгуульд ялагдсан ч энэ нь сонгогчдын дунд нэр хүндээ алдсан хэрэг биш юм. 1992 оны сонгуультай харьцуулахад МАХН-ын төлөө саналаа өгсөн хүний тоо 12.690-ээр өссөн үзүүлэлттэй байлаа. Гэсэн хэдий ч МАХН-ын хувьд сонгуулийн дүн нь гэнэтийн, сүйрлийн гэмээр ялагдал байлаа.

МАХН нь алдаандаа маш хурдан дүн шинжилгээ хийлээ. Намын удирдах боловсон хүчний нэг, сайд асан Ч.Пүрэвдорж нь МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Даш-Ёндонгийн (гүн ухааны мэргэжилтэй) намын үзэл бодлын жанжин шугам хэмээн тодорхойлсон гүн ухааны хуучинсаг бодол санаанд тулгуурладаг төв үзэл нь бурхангүй үзэлд автсан намын гишүүдийн хувьд удирдах үзэл бодол байж таарахгүй хэмээгээд үүнээс шалтгаалан МАХН-ыг үндэсний хэмжээнд болоод олон улсын тавцанд тусгаарлагдмал байдалд хүргэсэн гэж дүгнэлээ. Энэ жанжин шугамыг баримталснаас МАХН, ард түмний холбоо тасарсан хэмээн Ч.Пүрэвдорж дүгнэж: "Нам гэдэг байшин барилга биш, сургаал ч биш, харин хүмүүсийн нэгдэл юм" хэмээжээ. Түүний үзэж буйгаар хүн амын дунд ядуурал түргэн газар авч байгаа үед бүрдүүлсэн Засгийн газартаа нийгмийн чиг хандлагыг илүү хүчтэй тусгаж чадаагүйгээс ялагдсан байна.²

1996 оны 7 дугаар сард МАХН-ын 8 дугаар бага хурлыг зарлан хуралдууллаа. Хурлын төлөөлөгчид сонгуульд ялагдсан байдлаа дүгнэн хэлэлцэж боловсон хүчний хувьд шинэчлэлт хийлээ. Үүнд Н.Энхбаярыг Ерөнхий нарийн бичгийн даргаар, Ө.Энхтүвшинг нарийн бичгийн даргаар сонгож, МАХН-ын Удирдах зөвлөлийг шинээр бүрдүүллээ.

Намын удирдагчид нь хоёулаа залуу, ухаалаг, уян хатан байлаа. Н.Энхбаяр нь М.Горькийн нэрэмжит Москвагийн Утга зохиолын дээд сургуулийг дүүргэсэн, нүдэнд илүү дулаахан, нарийн мэдрэмжтэй, сэхээтний дүр төрхийг илэрхийлж байхад, Ө.Энхтүвшин илүү ажил хэрэгч, сэтгэлгээ сайтай хэрэгжүүлэгч болохоо харуулж, үүссэн нөхцөл байдалд шуурхай дүгнэлт хийж, нарийн зохион байгуулалттай, үр нөлөө бүхий үндэс суурийг бүрдүүлж чаддаг байв. Ойр дотных нь хүмүүс "компьютер" тархитай хэмээн тодорхойлсон Ерөнхий сайд асан П.Жасрайн араас Н.Энхбаяр, Ө.Энхтүвшин, улс төрийн асар

² Ч. Пүрэвдорж, Шавартай гараар нулимсаа арчиж хэрэггүй, Үнэн, 1996.07.30.

их туршлага, нарийн тооцоотой, олон улсын түвшинд дээд зэргийн харилцаа холбоо тогтоосон, парламент дахь МАХН-ын бүлгийг удирдах болсон Н.Багабанди нарын эрч хүчтэй гурвал гарч ирлээ.

Боловсон хүчний асуудал шуурхай шийдэгдэж байсан ч МАХН нь энэ үед гүн хямралд орсон байсан юм. Намын дотор жанжин шугамын, байр суурины төлөөх тэмцэл эхэллээ. Өөрчлөн шинэчлэх нь зайлшгүй болсон үзэл бодлын үндэс, намын шинэтгэлийн агуулгын талаар маргаж байв. Намын удирдах олон гишүүд 20-иод оны дунд үеийг хүртэл намын бодлогыг тодорхойлж байсан МАХН-ын үндэсний - ардчилсан шинжтэй уг үндсийг сэргээхийг санал тавьж байлаа. Ганцхан намын нэрийн талаарх маргааны үеэр л гэхэд "Монголын Либерал Ардчилсан Нам", "Монголын Иргэний Ардчилсан Нам", хуучныхаар нь "Монголын Ардын Нам" болгон өөрчлөх саналууд гаргаж байсан нь санал бодлоос солилцох, хэлэлцэх явдал анхны агуулгаас хальж, үзэл бодол нэгдэж чадалгүй олон чиглэлд хуваагдаж байсныг харуулна. МАХН хагаран бутрах аюул тун ч ойрхон нүүрлээд байв. Намын дотоод байдал хурцадсан энэ үед гаднаас гэнэтийн гэмээр нэг дохио хүлээн авлаа.

АХ-ны Засгийн газар засаг захиргааны төдийгүй нөлөө бүхий бүх түвшин дэх МАХН-ын боловсон хүчнийг халж солихоор шамдлаа. Үйл явц зөвхөн төрийн байгууллагуудыг дайраад өнгөрсөнгүй, их дээд сургуулиудын захирлууд, улсын зарим үйлдвэрийн дарга нарыг ч хамарсан юм. МАХН-аас нийтэлсэн тоо баримтаар бол үүнд 1200 орчим хүн өртсөн аж. Өрнөдийн ардчилсан нийгэмд ч гэсэн зарим үед ийм арга хэрэглэдгийг мэдээгүй байсан монголчуудын хувьд энэ нь урьд үзэгдээгүй явдал болсон юм. Гэвч АХ халж сольсонтойгоо дүйцэх хэмжээний боловсон хүчний нөөцгүй байсан тул яваандаа зарим талаар мэдлэг мэргэжлийн алдагдалд хүрч, монголын ард түмний хязгаарлагдмал нөөцтэй харьцуулахад нэлээд аюултай хандлага бий болж эхлэв. АХ-ны удирдлага хамтран ажиллах хүсэлтэй, өөрсдөд нь нааштай ханддаг МАХН-ын зарим боловсон хүчнийг огт анхааралгүй орхисоноос тэдний бодол эргээд татгалзах байдлаар солигдсон байна. Ямар нэгэн "өөриймсөг" үзэл бодол МАХН-ын гишүүдийг эргүүлэн нэгтгэж, намын дотоод сахилга батыг бэхжүүлэх, гадагшаа хаалттай байхыг шаардсанаар МАХН-ын удирдлагад илүү хялбар дөхөм болж ирлээ.

Орсон нутгийн сонгууль

МАХН-ын удирдлага 1996 оны 10 сард болох орон нутгийн сонгуульд бэлтгэх ажилд хүч чадлаа бүрэн дайчилсан юм. Тэд дэмжигч, бүтцийн бүх нэгжээ дайчиллаа. "Намын Үнэн" сонины

үршид тус сонгуулийн ач холбогдлыг удаа дараа тэмдэглэсэн байдаг. МАХН-ын удирдах зөвлөл сонгуулийн бэлтгэл ажлыг дараах чиглэлд төвлөрүүлжээ:

1. Намын орон нутаг дахь нөлөөг нэмэгдүүлэх,
2. Намын орон нутаг дахь байгууллагыг хадгалж үлдэх,
3. Орон нутгийн сонгуулиар зохих үр дүнд хүрснээр, парламентийн сонгуулиар алдагдсан хүчний тэнцвэрт байдлыг сэргээх,
4. Төрийн төвлөрсөн тогтолцоо, орон нутгийн эрх баригчдын нийгэм эдийн засгийн бодлогыг хянах бололцоог бүрдүүлэх,
5. Орон нутгийн төр, засаг захиргааны байгууллагад ажиллаж буй намын гишүүдийг халж солихыг эсэргүүцсэн тэмцлийг эрчимжүүлэх.³

Парламентийн сонгууль, орон нутгийн сонгуулийн хооронд чанарын томоохон ялгаа буйг АХ-ны удирдлага мэдэж байсан. Орон нутагт сонгуулийг хувь хүмүүс, намуудын анхан шатны тогтолцоо буюу хийж гүйцэтгэсэн ажил шийдэх байлаа. Гэтэл ялангуяа АХ-ны хувьд анхан шатны тогтолцоо сулын дээр хүн амын дунд уур амьсгал эрс өөрчлөгдсөн байв. Үнийг чөлөөлж, төрийн өмчийн орон сууцыг хувьчилна гэж засгийн газраас зарласан нь тайван байдлыг алдагдууллаа. Ард түмэн тэртээ тэргүй бэрхшээл дүүрэн амьдралаа улам дордохоос эмээж байв. 6 дугаар сарын сонгуулиар аль намын төлөө саналаа өгсөн талаар нийслэлчүүдээс асуухад бүгд МАХН-ыг сонгосон мэт санагдаж байсан юм. АХ энэ байдлыг зогсоохоор шийдэж Улсын Их Хурал (УИХ) "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийг шинэчлэн найруулж 9 дүгээр сард баталлаа.

АХ-ны удирдлага хүн амын дунд үүссэн уур амьсгалын эргэлт 1996 10 дугаар сарын 6-ны өдрийн сонгуулийн үр дүнд нөлөөлөх вий хэмээн эмээж байсан нь бодит үнэн болсон юм. МАХН Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Говь-Сүмбэр, түүнчлэн нийслэл Улаанбаатарт ялалт байгуулсан бол АХ ердөө Архангай, Баян-Өлгий, Дорнод, Хэнтий, Орхон аймгуудад ялав. М.Энхсайханы Засгийн газар МАХН-аас засаг даргад нэр дэвшигчдийг саатуулах зорилгоор маргаантай байдал өрнүүлж эхэллээ. Ингээд Ерөнхий сайд М. Энхсайхан Булган, Ховд аймгуудын засаг даргаар Ц.Раднаа, Д.Загджав, эсвэл О.Саалуу (МАХН) нарыг томилохоос татгалзаж байв.

³ Орон нутгийн сонгуулийн дүн, түүнээс хийх улс төрийн дүгнэлт, сургаамж, Үнэн, 1996.12.11

Орон нутгийн сонгуулийн дүн⁴

(1 – хүн амын тоо, 2 – иргэдийн төлөөлөгчдийн хурлын мандат, 3 – МАХН, 4 – АХ, 5 – МУНН, 6 – /МАХ/, 7 – бие даагч)

| Аймаг/хот | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|-------------|------------------|-------------|-------------|-------------|----------|----------|-----------|
| Архангай | 100.842 | 380 | 152 | 226 | - | - | 2 |
| Баян-Өлгий | 82.159 | 265 | 125 | 138 | - | - | 2 |
| Баянхонгор | 86.025 | 405 | 198 | 207 | - | - | - |
| Булган | 60.546 | 320 | 181 | 135 | - | - | 4 |
| Говь-Алтай | 72.921 | 363 | 220 | 142 | - | - | 1 |
| Дорноговь | 45.734 | 250 | 161 | 89 | - | - | - |
| Дорнод | 79.869 | 275 | 125 | 150 | - | - | - |
| Дундговь | 50.511 | 305 | 168 | 136 | - | - | 1 |
| Завхан | 101.443 | 480 | 255 | 225 | - | - | - |
| Өвөрхангай | 111.561 | 390 | 201 | 189 | - | - | - |
| Өмнөговь | 44.686 | 285 | 180 | 105 | - | - | - |
| Сүхбаатар | 55.850 | 255 | 150 | 103 | 2 | - | - |
| Сэлэнгэ | 93.260 | 335 | 192 | 139 | - | 3 | 1 |
| Төв | 103.721 | 536 | 311 | 223 | - | - | 2 |
| Увс | 99.624 | 400 | 225 | 172 | - | - | 3 |
| Ховд | 88.492 | 350 | 199 | 151 | - | - | - |
| Хөвсгөл | 117.678 | 460 | 213 | 244 | - | - | 3 |
| Хэнтий | 70.267 | 358 | 153 | 201 | - | 4 | - |
| Дархан-Уул | 87.084 | 91 | 48 | 43 | - | - | - |
| Улаанбаатар | 621.100 | 255 | 148 | 106 | - | - | 1 |
| Орхон | 59.105 | 45 | 21 | 24 | - | - | - |
| Говь-Сүмбэр | 11.931 | 55 | 34 | 21 | - | - | - |
| Нийт | 2.244.409 | 6858 | 3660 | 3109 | 2 | 7 | 20 |

Тэрээр дээрх алхамаа Үндсэн Хууль-ийн 60 дугаар зүйлийн гуравдахь хэсэг, "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай"⁵ хуулийн 10 дугаар хэсгийн 1 дэх хэсгийн заалтыг үндэслэн тайлбарлаж байсан боловч тус аймгууд дахь сонгуулийн дүн нэгэнт илэрхий байсан тул санаагаа сонгогчдод хүргэхэд бэрхшээлтэй байв. Тиймээс засгийн газрын шийдвэр ажил хэрэгч бус

⁴ Ардын Эрх, 1996.11.01

⁵ Монгол Улсын Хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ардын Эрх, 1996.09.12

санагдаж, түүнд итгэх хараахан бэхжиж амжаагүй итгэлийг сэвтүүлж орхисон билээ.

Үүссэн эдгээр нөхцөл байдал МАХН-ын удирдлагаас боловсруулсан хөтөлбөрийг итгэл үнэмшилтэй болгож, үзэл бодлын маргаанаа шуурхай шийдвэрлэхийг шаардсан юм. Намуудыг ажиглахад үндэсний ардчиллын дасгалыг гүйцэтгэх шаардлагагүй болсон мэт санагдахаар байлаа.

“Ардчилсан социализм” – ухралт уу, шинэ эхлэл үү?

Нийгмийн асуудал улам хурцаар тавигдаж байсан энэ үед МАХН социалист уламжлалаа эргэн саналаа. МАХН-ын “Үнэн” сонин намын социалист уламжлалын талаар уншигчидтайгаа 1996 оны 10 дугаар сараас санал солилцож эхэлсэн. Энэ үйл ажиллагаа зохих үр дүнгээ өгсөн юм. Учир нь МСДН хэдийгээр өөрсдийгөө “социал-демократ” хэмээн нэрлэсэн ч уг ойлголтоо шингээж чадаагүй, зөвхөн уриа, зурагт хуудас маягаар авч явснаас үүдэлтэй. Түүнчлэн МСДН-ын зарим улс төрчид нийгмийн халамж нь хүлээн зөвшөөрөгдсөн анхан шатны байгууллагын эрчимтэй үйл ажиллагаагаар тодорхойлогддог болохыг ойлгоогүй байлаа. Үүнээс гадна МСДН-д орон даяар тархсан, мэдлэг боловсролтой, идэвхи санаачилга гарган ажиллах боловсон хүчин бүхий бүтцийн нэгжийн сүлжээ дутагдсан.

1996 оны 10 дугаар сард Үнэн сонинд гарсан нэгэн нийтлэлд МАХН-ын удирдлагын зарим хэсэг нь Социалист Интернациональд намаа гишүүнээр элсүүлэхээр хандах бодолтой байгаа тухай⁶ анх бичлээ. Шалтгаан нь тодорхой байв. Социалист уламжлалаа сэргээснээр МАХН олон улсын хэмжээнд шинэ түншлэгч хайж олох шаардлагатай болсон юм. Үүний тул Орос улсаас эхлэн холбоо тогтоох нь уламжлалын төдийгүй хувь хүний харилцааны үүднээс ч илүү боломжтой болох нь ойлгомжтой хэрэг. МАХН нь Оросын Коммунист намаас бүх холбоогоо тасалж, харин ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга И.П.Рыбкиний удирдсан, Б.Н.Ельцинтэй их ойр холбоотой гэгдэх Оросын Социалист Намтай эрчимтэй холбоо тогтоосон юм. Намын дарга Н.Энхбаяр 11 дүгээр сарын эхээр И.П.Рыбкинтэй намуудын албан ёсны харилцааны тулгын чулуу тавихаар Москвад айлчилсан байна. Энэ уулзалтын үеэр МАХН-ын боловсон хүчнийг ОХУ-д бэлтгэх тухай ч ярьжээ.⁷

⁶ Н. Дашзэвэг, МАХН шинэчлэгдвэл баруун луу гулсах уу, зүүн хэвээрээ байх уу?, Үнэн, 1996. 10.22

⁷ МАХН, ОСН-ын дээдлэх үнэт зүйл адилхан, Үнэн, 1996. 11.12

Парламент дахь МАХН-ын бүлгийнхэнд сөрөг хүчний үүргийг гүйцэтгэх нь амаргүй байлаа. 70 жил засгийн эрхийг тасралтгүй барьсан намын хувьд тийм ч гайхаад байх зүйл биш болов уу. Харин орон нутгийн сонгуулийн дараагаар МАХН-ын гишүүдийн эгнээнд өөртөө итгэх итгэл асар өссөн байлаа. МАХН-ын Удирдах зөвлөлөөс 1996 оны 11 дүгээр сарын эхэнд сүүдрийн засгийн газар байгуулахаар шийдвэрлэлээ. АХ нэгдмэл цул биет биш юм байна гэдгийг намын удирдлага нэгэнт ойлгожээ. Ц.Чулуунбаатар, П.Улаанхүү нарын МСДН-ын "чөлөөт ардчилсан" жигүүрийнхэнтэй албан бус уулзалт хийх нь жирийн үзэгдэл болжээ.⁸ МСДН-ын дэд дарга С.Баярцогттой ч ярилцаж байлаа. Тэрээр 1996 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Үнэн сонинд өгсөн ярилцлагадаа "Ер нь МҮАН - МСДН сонгуулийн өмнө эвсэл болсноор энэ дөрвөн жилд эвслийнхээ үйл ажиллагааг нэгдсэн нэг нам шиг тийм байр сууринаас хэрэгжүүлэх ёстой. Тэр нь бол гарцаагүй. Хоёр нам нэг нам болж нэгдэх асуудал тусдаа өөр зүйл. Нэгдэх эсэх нь намын улс төрийн байгууллагууд, гишүүдийн хүрээнд шийдэгдэх ёстой асуудал юм."⁹ гэжээ. МҮАН ямар нэгэн байдлаар үзэл бодлын хувьд чөлөөтэй, шилжилтийн үеийн иргэний хөдөлгөөнөөс үүсч, харин МСДН бол МАХН-ын эсрэг, зүүн жигүүрийн нам байхаар үүссэн хүчин зүйл нь МАХН-ын хувьд сонирхох асуудал байсан болов уу. Учир нь өөрчлөн шинэчлэгдсэн МАХН-д социал-демократ үзлийг хүлээн зөвшөөрөхөөс хэтрээгүй МСДН-ын орших эсэхийг шийдэх чадвар бий болох магадлал байгаа. 1996 оны 9 дүгээр сард үнийг чөлөөлсөн нь нийгэмд олон төрлийн зөрчилдөөний голомтыг үүсгэсэн байлаа. Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ жилийн хоёр дахь хагаст 40 орчим хувиар өссөн байхад, цалин хангамж хуучнаараа байв. Хүн амын бодит орлого 32 орчим хувиар буурлаа. Эдгээр заналхийллийн өмнөөс зүүн жигүүрийн нийгмийн энх тунх байдлыг эрхэмлэгч намын хувьд хүн амд хүлээн зөвшөөрөгдөх арга хэрэглэн сөрөн зогсох байсан. Гэтэл үйл ажиллагаа нь нийгмийн бодит байдлыг гүйцэхгүй байлаа. Нэмээд хэлэхэд тэрээр МҮАН-ын зорилгоо хэрэгжүүлэх хэрэгсэл л байсан билээ.

1996 оны 11 сард улс төрийн үймээн дэгдлээ. 11 дүгээр сарын 22-нд Засгийн газрын хэвлэл болох Ардын Эрх сониноор МАХН-ын тэргүүний улс төрчид болох П. Жасрай, Н.Энхбаяр, Ж.Гомбожав, Ө.Энхтүвшин нарын утсыг Тагнуулын төв газраас чагнаж байжээ хэмээн зарлав. Энэ алба М.Энхсайханы шууд харьяалалд байсан тул, уг асуудал нь сөрөг хүчнээс АХ-ны Засгийн газар луу шууд довтлох шалтаг болж өглөө. Гэхдээ чагнах үйл ажиллагааг М.Энхсайханы заавраар

⁸ Үнэн, 1996.11.01

⁹ С. Баярцогт, Би МАХН-д сайнаар ханддаг, Үнэн, 1996.11.26

бүс, харин тус албаны дарга, генерал Ж.Баатарын санаачилгаар хэрэгжүүлсэн байхыг үгүйсгэх аргагүй. Сөрөг тагнуулын “хөгшин бурхи” Ж.Баатар¹⁰ нь П.Жасрайн Засгийн газрын үед тодорхой шалтгаанаар, “өөрчилдөөний” улмаас ажлаасаа халагдаж байсан байна. Ерөнхий байд М.Энхсайхан түүнийг 1996 оны 9 дүгээр сарын 5-нд хуучин ажилд нь эргүүлэн томилсон билээ. С.Зориг, О.Дашбалбар, Ц.Нямдорж, Р.Одонбаатар нарын бүрэлдхүүнтэй парламентийн хороо томилогдон ажиллаж, энэ хэргийг судалж үзсэн байна. Уг хорооноос дүгнэлт гаргаж, нээлттэй зарим асуудал батлагджээ. Ж.Баатарыг үүрэгт ажлаас нь огцруулж, Тагнуулын төв газрыг татан буулгаж, Улсын аюулгүй байдлыг хангах газар нэртэйгээр өөрчлөв. (Шинэ албаны даргаар Ц.Энхнасан, дэд даргаар өмнө нь төв газрын дэд дарга асан Д.Чимэд-Юндэн нар томилогдов) МАХН Засгийн газраас утас чагнасан хариуцлагаа хүлээж огцрохыг шаардав. МАХН, АХ-ны Засгийн газраас огцрохыг анх удаа шаардсан нь энэ.

МАХН-ын XXII. Их хурал – хөтөлбөр дахь эргэлт

1996 оны 7, 8-ны өдрүүдэд хуралдсан МАХН-ын 7 дугаар бага хурлаас МАХН-ын XXII Их хурлыг 1997 оны 2 дугаар сарын 21-ээс 23-ны өдрүүдэд зарлан хуралдуулахаар шийдвэрлэв. Үнэн сонинд гарсан нийтлэлээс үзэхэд тус хурлаар намын хөтөлбөрийг бүхэлд нь социалист үндэст тулгуурлан өөрчлөх нь мэдрэгдэж байлаа. УИХ-ын МАХН-ын бүлгийн гишүүн Ц.Товуусүрэн “Үнэн” сониноор дамжуулж: “Өнөөдөр “Ардчилсан Холбоо” эвсэл либерализмыг гол тугаа болгож ард түмнээ чадалтай нь баяж! чадал муутай нь ядуур! гэсэн чиглэлийг илэрхий баримтлах болов. Энэ үед МАХН социалист нам болж зүүний чиглэлийг тов тодорхой баримтласан үзэл онолтой нам болон өөрчлөгдөх явдал юу юунаас чухал... Харин намын гишүүдийн олонхи нь социалист чиглэлийн үзэл баримтлалтай гэдэгт миний бие огтхон ч эргэлздэггүй.”¹¹ гэж шаардаж байсан нь ойлгомжтой байна. Ц.Товуусүрэн МАХН-ыг “социалист” нам гэдгийг хөтөлбөртөө тодорхой тусгаж, үүгээрээ ялангуяа 30–45 насныхныг татаж болох юм гэж заасан байдаг. Энэ насныхан нь 1998 онд гаргасан хүн амын тоогоор авч үзэхэд ямар ч байсан сонгуулийн эрх бүхий хүн амын 37,5 хувийг бүрдүүлж байсан юм. Сонгуулийн стратегийн хувьд ач холбогдол нь 18 хүртэлх насны

¹⁰ Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат 1990 оны 10 дугаар сарын 22-нд Ж. Баатарыг Улсыг Аюулаас Хамгаалах Газрын даргаар томилж, хошууч-генерал цол олгожээ.

¹¹ Ц. Товуусүрэн, Гишүүдийн олонхи социалист чиг баримталдаг гэдэгт би эргэлздэггүй, Үнэн, 1996.12.07

хүүхэд залуучууд буюу нийт хүн амын 47,46 хувийг бүрдүүлэгч хүн амыг эдгээр хүмүүст ногдоход оршиж байв.¹²

МАХН-ын эгнээнд үүссэн өөртөө итгэх шинэ итгэл нь өөр дуу хоолойг ч мөн бий болгосон юм. Ж.Роозон үүнийг Үнэн сонинд нийтэлсэн "Урвагчид" гэсэн нийтлэлдээ тодорхойлов: "МАХН-ын шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд томоохон алхам болох ээлжит Их хурлын хугацаа ойртох тутам гишүүд, дэмжигчид санал бодлоо хэлэх нь улам ихсэв. Эдгээр саналын дотор намыг урвагчдаас цэвэрлэх асуудал багагүй байр эзэлж байна. Манай нам том учраас урвагчид нь жижиг намуудаас олон бололтой." гэжээ. Ж.Роозонгийн хэлснээр: "... Эзэн Чингис нарын ихэс дээдэс өөрийн болон дайсны урвагчдыг өршөөдөггүй байсан."¹³ гэжээ. Эдгээр "урвагчид" хэн болох нь төдөлгүй тодорхой болох ажээ. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Б.Даш-Ёндон Үнэн болоод Улаанбаатарын намын хорооны сонинд нийтлэл бичиж, үүнийгээ намын их хурлын төлөөлөгчдын дунд тарааж ч амжсан байна. Тэрээр "ардчилсан социализмын" ойлголтыг эсэргүүцэж: "ардчилсан социализм" гэгч огт байхгүй зүйл гэжээ. Б.Даш-Ёндон тухайн цаг үеийн шинжтэмдгийг ойлгоогүй бөгөөд улмаар шүүмжлэлийн бай болов. Гэвч Ерөнхий нарийн бичгийн дарга асны хүсэл зоригийг ойлгож болох байсан юм. Учир нь тэрээр сүүлийн хэдэн жилийн туршид дэмжиж байсан төв үзлийнхээ улмаас өөрт чиглээд байсан шүүмжлэлийг эсэргүүцэн тэмцэхээр шийдсэн нь энэ байлаа.

МАХН-ын дарга Н.Энхбаяр намын их хурлаас өмнө Японыг зорилоо. Энэ айлчлалын талаарх Үнэн сонины мэдээ нэлээд бүрхэг байв. Энд: "Японы дэвшилтэт хүмүүс ... МАХН-ыг дэмжиж буйгаа илэрхийлж МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Энхбаярыг урьж, МАХН-ын XXII Их хурлын өмнө Монголын нийгэм дэх улс төрийн өөрчлөлтийн талаар илтгэл тавихыг хүслээ" гэжээ.¹⁴ Урилгыг Agarform гэх жижиг болоод дунд шатны хувийн үйлдвэрлэгчдийн байгууллагаас ирүүлсэн байлаа. Н.Энхбаяр энэ боломжийг ашиглан МАХН-тай олон жилийн туршид хамтран ажиллаж ирсэн Либерал Ардчилсан нам (ЛАН)-ын удирдлагуудтай уулзлаа. Н.Энхбаяр ЛАН-ын удирдлагуудад МАХН-ын хөтөлбөрийн өөрчлөлтийн талаар тайлбарлан яриу.¹⁵

¹² Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 1997, Улаанбаатар 1998, 28-29-р нүүр

¹³ Ж.Роозон, Урвагчид, Үнэн, 08.02.1997

¹⁴ Үнэн, 12.02.1997

¹⁵ Япончууд МАХН-ыг сонирхож байна. Үнэн, 1997.02.21. Японы ЛАН-ын талаас түүнтэй ярилцсан хүмүүсээс парламентийн доод танхимийн гишүүд Окуна, Мацушита, Шиншинто, Яманага, түүнчлэн парламентийн доод танхимийн гадаад бодлогын байнгын хорооны дарга Кашита байлаа.

XXII Их хурал 2 дугаар сарын 21-ны өдөр эхлэхэд өмнөх үеийн боловсон хүчний бодлогоос бүрмөсөн салсан нь илт мэдрэгдэж байлаа. Анх удаагаа нийт 81.000 МАХН-ын гишүүдийг төлөөлж 591 төлөөлөгчдөөс 589 буюу 99,3 хувь нь их хуралд оролцлоо. Нийт оролцогч гишүүдийн нэрс, намын их хурал чуулахаас бусад үед намын дээд байгууллага болох намын бага хурлын гишүүдэд сонгогдсон хүмүүсийн нэрсээс үзэхэд гадагшаа нэг чухал зүйлийг илэрхийлсэн юм. МАХН нь улсын үйлдвэрийн олон тооны захирлууд, түүнчлэн хувийн үйлдвэрийн эздийн итгэлийг олж авсан байлаа.

Намын Их хурлын хамгийн гол асуудал нь гарцаагүй намын улс төрийн жанжин шугамыг шинээр тодорхойлох явдал байсан бөгөөд энэ нь зөвхөн монголчуудын анхаарлын төвд байсангүй. А.Яманака МАХН-ын Их хуралд дэвшүүлсэн мэндчилгээндээ: "... Бид өнөөдөр хаана байна вэ, хаашаа явж байна вэ гэдгийгээ мэдэх ёстой. Иймээс Монгол, Япон хоёр улс харилцан ойлголцож найрамдлаа хөгжүүлэх... төгөө хамтран ажиллаж байна. Би танай намын Их хурал болон хуралд оролцогсдод бүгдэд нь амжилт хүсье."¹⁶ гэжээ. Намын дарга Н.Энхбаяр төв үзлийг хатуу шүүмжилж: "Олон нийтийн нэлээд хэсэг нь төв ёсны үзэл бол цаг үе, манай нийгмийн өнөөгийн байдал тодорхой асуудлыг тодорхой байр сууринаас түргэн шуурхай шийдэхийг шаардаж байхад төвийг сахин идэвхгүй байхын нэр хэмээн ойлгодог. Ийм ч учраас намын гишүүдийн дийлэнх олонх нь төв үзлээс татгалзахыг шаардаж, харин түүнийг гагцхүү аливаа асуудалд намын байгууллагууд төвч, голч байр сууринаас хандах арга зүйн удирдлага хэмээн төсөөлдөг билээ."¹⁷ Төв үзлийг шүүмжилсэн Н.Энхбаярын шүүмжлэл нь зэрэгцээд Б.Даш-Ёндон болоод түүнийг дэмжигчдийн эсрэг чиглэсэн байлаа. Шүүмжлэлийн практик ач холбогдол нь үзэл бодлын хатуу байр суурь баримтлагч хуучны "аппаратчик"-уудын жигүүрийн намын удирдлага дахь нөлөөг бүрмөсөн арилгасан явдал юм. Намын Их хурлаар намын цоо шинэ хотөлбөр, дүрмийг баталж, шинэ эхлэлийг тавих ёстой байв. Гэвч намын гишүүдийн дунд ялангуяа намын үзэл бодлын талаар ярилцах, санал солилцох шаардлага нэлээд байсан бололтой. Тиймээс намын стратегийг боловсруулагчид нь Үнэн сонины 21 өдрийн дугаарт "хуучин социализм", "ардчилсан социализм"-ын хоорондох зарчмын ялгааг хамгийн сүүлчийн гишүүнд хүртэл таниулах зорилгоор нэгэн хүснэгтийг нийтлүүлжээ.

¹⁶ Гадаадынхнаас Их хуралд баяр хүргэсэн нь, Үнэн, 1997.03.01

¹⁷ Н. Энхбаяр, МАХН-ын шинэчлэлийн тулгамдсан зорилтууд, МАХН-ын XXII Их хурал, Улаанбаатар 1997.02.21-24. 18 дугаар нүүр; Үнэн, 1997.02.22

Ардчилсан социализм юугаар ялгаатай вэ?

| Хуучин социализм | Ардчилсан социализм |
|--|--|
| Нэг үзэл бодлын ноёрхол Нэг намын тогтолцоо Пролетарийн диктатур Хүний эрх, эрх чөлөөг үзэл бодлын болоод Ангийн ялгаагаар хязгаарлах | Үзэл бодлын олон чиглэл Олон намын тогтолцоо Парламентат төр Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах |
| Төрийн өмч давамгайлах Төлөвлөгөөт эдийн засаг | Төрийн, хоршооны, хувийн өмч бүхий холимог эдийн засаг Зах зээлийн нөхцөлд нийцүүлэн зөвлөлдөх замаар төлөвлөгөөг хэрэгжүүлэх |
| Нийгмийн бэрхшээлийг зарчмын хувьд төрөөс шийдвэрлэх Оюун санааны амьдралыг үзэл бодлоор тодорхойлох | Хүний өөрийн оролцоог төрийн дэмжлэг, оролцоотой холбох Оюун санааны эрх чөлөө |

Энэ хүснэгт ихээхэн “ашиг” авчрав. Үүний дагуу бол “ардчилсан социализм”-ийг бараг хэрэгжүүлчихсэн байх агаад харин гагцхүү цаашид оршин тогтнох баталгааг бэхжүүлэх - үүнийг мэдээжийн хэрэг – ганцхан МАХН л хэрэгжүүлж чадах ажээ.

Үнэн сонин тус дугаартаа нийт арван таван аймгийн болоод Улаанбаатар хотод намын 3000 гишүүнээс авсан гэх санал асуулгын дүнг нийтэлжээ. Оролцогчдын 80.2-оос 88.9 хувь нь “ардчилсан социализмыг үзэл бодлын онол - ёс суртахууны үндэс болгохын төлөө” санал өгчээ. Намын даргаар хэнийг сонгох хүсэлтэй байна вэ гэсэн асуултад санал асуулгад оролцогчдын 56.1 хувь нь Н.Энхбаяр, 10.8 хувь нь Н.Багабанди, 4.0 хувь нь Ч.Улаан, 3.2 хувь нь Ө.Энхтүвшин, 2.9 хувь нь Б.Даш-Ёндонгийн төлөө саналаа өгчээ. Харин тэд үүний дараагаар: “хамгийн олон санал авсан эхний 5 хүнээр тодорсон байна.”¹⁸ гэсэн нь тэмдэглүүштэй юм. Санал асуулгын “дүн” эргэлзээ төрүүлсэнгүй, Б.Даш-Ёндон болоод түүний дэмжигчдийг зайлуулсан нь тодорхой боллоо. Анх харахад төв үзэл нь намын хувьд үр бүтээлгүй байсан нь илэрхий. Дахин харахад харин энэ үзлийг хэрэглэх нь өөр учир холбогдолтой байсан ажээ. Чиг баримжаагүй бэйх үед төв үзэл нь хөтөлбөрт бий болсон “агааргүй” орчинг ямар нэгэн байдлаар дүүргэж, нөгөө талаар МАХН-ыг марксизм, ленинизмээс бүрэн ангижирсан гэх сэтгэгдлийг төрүүлж

¹⁸ Судалгааны дүн юу харуулав?, Үнэн, 1997.02.21

байв. Намын Их хурлын төлөөлөгчид Их хурлын ажиллагаа дуусах үед намын шинэ хөтөлбөрийг батлав. МАХН-аас өөрийгөө тодорхойлсны дотор: "... МАХН бол үндэсний шинжтэй нам мөн. Учир нь манай намын дэвшүүлэн тавьж байгаа зорилго үндэсний шинжтэй бөгөөд түүнд хүрэхийн тулд сонгон авсан улс төрийн үзэл баримтлалаа Монголын өвөрмөц онцлогтой уялдуулсан бодлогыг хэрэгжүүлнэ... МАХН бол зүүний нам мөн. Учир нь нийгэмд баян хоосны эрс ялгаралгүй, шударга ёс, тэгш эрх тогтсон нөхцөлд хүн, эрх чөлөөтэй хөгжих бололцоотой, энэхүү эрхэм зорилгыг гүйцэлдүүлэхэд төрийн ухаалаг бодлого, зохицуулалт чухал үүрэгтэй гэж үздэг... МАХН бол төвийн нам мөн. Бид нийгмийн хэсэг, давхарга, бүлгүүдийг алагчлан үзэхээс эрс татгалзаж, тэдний сонирхлыг оновчтой зохицуулахыг эрхэмлэж, хөгжил дэвшлийн асуудлыг хүчирхийллийн бус хувьслын аргаар шийдэх ёстой гэж үзэж байна. Манай нам энэ байр сууриа тунхаглаад зогсоогүй сүүлийн жилүүдэд Монгол оронд үүсч байсан улс төр, нийгэм - эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэхдээ энэ аргыг иш үндэс болгон хэрэглэж ирсэн билээ... Ардчилсан социалист үзэл санааны үндсэн агуулга нь эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийн зарчмуудаар тодорхойлогддог. Ардчилсан социалист үзэл нь хүнд бүрнээ итгэж, хүн, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг нийгмийн амьдралын аль ч хүрээнд тодорхой эрх эдэлж, эрх чөлөөтэй байх ёстой, хүн болон хамт олны хоорондын харилцаа, харилцан шүтэлцээтэй, ижил тэгш, аль нэг субъект нь нөгөө субъектээсээ илүү эрх эдлэх ёсгүй, нийгмийн шударга ёс, төр, нийгмийн зүгээс хүнд тавих анхаарал халамж бүх хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх үндсэн нөхцөл мөн гэж үздэгээрээ, ардчиллыг зөвхөн эрх чөлөөтэй биш бас нийгмийн шударга ёстой холбодгоороо, түүнийг зөвхөн улс төрийн хүрээгээр хязгаарлах бус, эдийн засаг, нийгмийн харилцаанд хамруулан өргөн хүрээтэй авч үздэгээрээ, нийгэм дотроо эв нэгдлийг чанад сахиснаар хүчирхийллийн бус хувьслын замаар урагш дэвшин хөгжинэ гэдэг зарчимд тулгуурлагдгаараа улс төрийн бусад үзэл онолоос илгаатай юм. Эрх чөлөө, шударга ёсны зарчмыг эн чацуу тавьж, гэдгээрт тулгуурласан ардчилсан ёсыг баримтлах нь Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүмүүнлэг, энэрэнгүй, иргэний ардчилсан нийгмийн үндсэн шинжийг бүрдүүлэх чухал хүчин зүйл болно гэж үзэж байна... Тиймээс МАХН ардчилсан социалист үзэл санааг баримталдаг болсноор хуучин руу эргэж буцахгүй юм..."¹⁹ гэжээ.

Улс төрийн тодорхойлолтыг социалист зарчимд нийцүүлж шинээр томъёолсон нь МАХН-ыг өмнө нь ямар хэмжээний коммунист

¹⁹ Н. Энхбаяр, МАХН-ын шинэчлэлийн тулгамдсан зорилтууд, МАХН-ын XXII Их хурал, Улаанбаатар 1997.02.21-24. 30-32 дугаар нүүр

нам байсан талаар асуулт тавихад хүргэсэн юм. МАХН-ын бүлгийн ахлагч Н.Багабанди ярилцлага өгөхдөө, сүүлд өөр ярилцлага, саналаа илэрхийлэх үед төсөөтэй хэлбэрээр олонтаа давтагдсан тодорхойлолтыг өгсөн билээ. Тэрээр: "МАХН анх үүссэн үеэсээ үндэсний ардчилсан шинжтэй нам байлаа. Коминтерн оршин тогтнож байсан цаг үед МАХН түүнийг талархагч улс төрийн хүч байснаас биш мөн чанараараа коммунист нам болж байгаагүй гэж түүхчид нотлодог юм билээ. Дэлхийн II дайны дараах үед МАХН-ын улс төрийн үзэл баримтлалд социалист хандлага аажмаар хүчтэй болсон нь хүйтэн дайны улмаас нийгэм, эдийн засгийн хоёр систем тогтсон нөхцөлд манай намын эзэлсэн байр суурь болон дотооддоо улс төрийн хөгжлийг түргэтгэхийн тулд социалист үзэл санааг удирдлага болгосон бодит байдалтай уялдаатай."²⁰ гэжээ. Энэхүү тодорхойлолтыг яаж ойлгох талаар маргаж болно. Гэхдээ МАХН нь зөвлөлтийн зөвлөхүүдийн дарамт шахалтыг үл харгалзан 20 оны дунд үеийг хүртэл намынхаа үндэсний ардчилсан үндсүүдийг хадгалан үлдэхийг чармайсан нь гарцаагүй үнэн бөгөөд эдгээр үндэс нь гагцхүү Сталины үеийн алан хядлага, хэлмэгдүүлэлтийн үед МАХН-ын эгнээний удирдах зүтгэлтнүүдийн дунд явуулсан цуст золиосны үр дүнд л бүрмөсөн устсан билээ.²¹ Мосвагийн чигийг идэвхтэй баримтлагч Ю.Цэдэнбал зэргийн улс төрчид үзэл бодлоор халхавч хийж монголын эрх ашгийг хэрэгжүүлэхээр оролдож байсан тухай олон баримт байдаг. Бусад намуудаас МАХН-ын түүхийг хэт нэг талын болгон тухайн үеийн зорилгодоо нийцүүлж мушгин гуйвуулах нь түүхийн үнэн мөнийг олох арга замд тохирохгүй бөгөөд иймэрхүү байдлаар тодорхойлсон түүхийн асуудал нь Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн халдашгүй байдалтай шууд холбогдсон байдаг.

МАХН-ын XXII Их хурлын бараг анхаарагддаггүй өөр нэг үр дүн бол намын удирдлагын бүтцийг шинээр тодорхойлогдсон явдал бөгөөд үүнээс шийдвэр гаргах үйл явц нилээд ардчилсан шинжтэй болсон нь харагдаж байна.

2 дугаар сарын 23-нд хурлын төлөөлөгчид намын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ю.Цэдэнбал агсныг намын гишүүнээс хассан 1990 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн МАХН-ын Төв хорооны 8 дугаар хурлын шийдвэрийг хүчингүй болгохоор шийдвэрлэлээ. Тэд Н.Энхбаярыг Ерөнхий нарийн бичгийн даргаар, Н.Багабандийг намын даргаар, Ө.Энхтүвшинг МАХН-ын нарийн бичгийн даргаар сонгов. Ө.Энхтүвшинг Улаанбаатар хотын МАХН-ын хорооны 9 дүгээр

²⁰ *Нэг мөр шийдвэрлэх түүхэн хувь заяа, Үнэн, 1997.02.21*

²¹ *Udo B. Barkmann, Geschichte der Mongolei oder die „Mongolische Frage“ Die Mongolen auf ihrem Weg zum eigenen Nationalstaat, Bonn, 1999*

хураалдаанаар нийслэлийн намын даргаар сонгосон билээ.

МАХН-ын шинэ удирдах зөвлөл хуучнаасаа эрс ялгагдаж байлаа. Гишүүдийн дундаж нас дөнгөж 43.8 нас байв. 54.5 хувь нь хуучин ЗХУ-д сургууль дүүргэсэн ба 27.27 хувь өмнө нь МАХН-д доод шатны алба эзлэдэг байлаа. Удирдах зөвлөлийн гишүүдээс эдийн засагч гурав, инженер хоёр, математикч нэг, хуульч хоёр, түүхч хоёр байв.

Ерөнхийлөгчийн сонгууль

Монгол иргэдийн үйлдлүүдийг ажиглахад ихэнхдээ улс төрийн прагматик шинж ноёрхож, тодорхойлж байна уу даа гэсэн сэтгэгдэл тэрхүү нь олонтаа. Тодорхой нэг нөхцөлд энэ сэтгэгдэл үнэн байж болох. Харин урт хугацааны ажиглалтаас үзэхэд энэ сэтгэгдэл буурдаг болохыг П.Очирбат Ерөнхийлөгчийн жишээнээс харж болно. Анх тэрээр МАХН-аас нэр дэвшиж, олон жилийн туршид МАХН-д нам, төрийн зүтгэлтний алба хашиж байсан бөгөөд, Ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараагаар "Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын" тухай хуульд (1991.08.28.) зааснаар МАХН-ын гишүүнчлэлээс татгалзаж, улс төрийн өөрөг хүчинд илүү найр тавих болсон юм. 1993 оны сонгуулиар тэрээр өөрөг хүчнээс нэр дэвшсэн юм. Гэвч 1997 онд уур амьсгал 1993 оныхоос эрс өөрчлөгдсөн байлаа. Дотоодод үүсээд байсан тогтворгүй байдал нь "чанга гартай" хүн шаардахад хүргэсэн. П.Очирбат хэт зөөлөн, хэт олон удаа хэт түргэн зөвшилцдөг, улс төрийн "салхийг дагадаг" гэсэн нэр зүүгээд байлаа.

1997 оны 4 сард МАХН-ын дэргэдэх "Прогноз" судалгааны төвөөс ерөнхийлөгчийн сонгуулийг угтаж арван аймаг, нийслэл Улаанбаатарт нийт 1800 хүний дунд дотоодийн өнөө үеийн улс төрийн байдал, удахгүй болох ерөнхийлөгчийн сонгуулийн талаар санал асуулга явуулжээ.²² Энэхүү санал асуулга нь ард түмний сэтгэл санааны байдлыг тодорхойлсон юм. Санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 40 хувь нь амьдрал урьд жилүүдийнхээс дордсон гэж үзжээ. 84.8 хувь нь цалин мөнгө хоол унд, орон байранд хүрэлцэхгүй байна гэжээ. Ингэж хэлсэн хүмүүсийн эзлэх хувь өмнөх жилд 36.9 байсан билээ. 72.7 хувь нь нийгэм эдийн засгийн байдлыг "муу/маш муу" гэж дүгнэсэн байна. 55.3 хувь нь энэ байдлыг Ардчилсан Холбоог засгийн эрхэнд гарсантай холбон авч үзжээ. Нам тус бүрийг хүн амаас үнэлж дүгнэх байдал аажмаар МАХН-д ашигтайгаар эргэсэн хэдий ч хараахан чанарын өөрчлөлт гараагүй байлаа. Асуулгад оролцогчдын 39.4 хувь МАХН-ыг дэмжихээ илэрхийлж, 30.7 хувь Ардчилсан Холбоог дэмжиж байв. МАХН-ын удирдлага хүн

²² Сонгогч-сонгууль-ерөнхийлөгч, Ардын Эрх, 1997.04.19

амын санаа бодлыг ийнхүү судалж үзээд 5 дугаар сарын 15-нд болох сонгуульд сайтар бэлтгэж эхэллээ. МАХН-аас тактикийн олон хувилбар боловсруулж, удирдах зөвлөлийн 1997 оны 3 дугаар сарын 10-ны шийдвэрт тусгаснаар бусад намтай хамтран ажиллахаар зэхэж байжээ. Гэтэл 3 дугаар сарын 14-нд Монголын Уламжлалын Нэгдсэн нам (МУНН) тохиролцоонд хүрэхээс татгалзсан билээ.

Намын 2 дугаар Бага хурлын үеэр МАХН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулахаар Н.Багабанди, Ж.Гомбожав, П.Жасрай, Л.Түдэв нарын нэрийг оруулж бага хуралд оролцогчдын 71.93 хувийн саналаар Н.Багабандийг сонголоо. Тэрээр Монгол улсад хэдийнээ танил болжээ. 1990 оноос хойш Ардын Үлсын Их хурлын дарга, МАХН-ын өндөр албуудыг хашиж ирсэн бөгөөд 1996 онд түүнийг МАХН-ын УИХ дах бүлгийн ахлагчаар сонгосон байлаа. Н.Багабанди нь шийдвэрээ сайтар бодож боловсруулж, үр дагавартай нь хамтаар хэрэгжүүлдэг гэгдэж байсан бөгөөд "чанга гартай" хүний тодорхойлолтод нэлээд ойртож очиж байлаа.

АХ-ноос П.Очирбатын нэрийг дэвшүүлсэн нь маргаантай асуудал байв. Үндсэн Хууль-ийн 31 дүгээр зүйлийн 7-д Ерөнхийлөгчийг бүрэн эрхийн нэг хугацаанд сонгохоор заажээ. Энэ заалтын дагуу 1993 оны 6 дугаар сарын 18-нд ерөнхийлөгчийн албаа "бүх ард түмний" сонгуулиар баталгаажуулсан П.Очирбат нэр дэвших эрхгүй болоод байсан юм.

МАХН-ын Бага хурлаас нэрээ дэвшүүлж чадаагүй Ж.Гомбожав энэ хооронд МАХН-аас гарч, МУНН-ын дэмжлэгтэйгээр нэр дэвшлээ. Тэрээр нэгэн ярилцлагадаа Монголд 12 нам үйл ажиллагаа явуулж буйг шүүмжлээд, Монгол Улсын хувьд туйлшрал хүчээ авах шаардлага байхгүй бөгөөд харин хүчний тэнцвэрт байдал хэрэгтэйг хэллээ. Намаасаа гарсныг тэрээр маш энгийн зүйл гэж үзсэн юм. Учир нь МАХН-аас 20000 гишүүн гарч, Р.Гончигдорж, М.Энхсайхан, П.Очирбат нар ч гэсэн МАХН-ын гишүүд байсан билээ.²³ Гэвч Ж.Гомбожав намаасаа гарч, ерөнхийлөгчид нэр дэвшсэн нь тохиолдлын зүйл төдий биш, Н. агабандид ашигтай байхаар саналыг бутаргах зорилготой байсан байж болох. Санал асуулгын дүнгээс Н.Багабанди түрүүлж байсан нь тодорхой байв.

²³ Ж. Гомбожав, *Туйлшрал, намчирхлаас болж нийт ард түмний эрх ашиг хохирч байна, Засгийн газрын мэдээ, 1997.05.06*

Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн талаарх санал асуулга²⁴

| Огноо | П.Очирбат | Н.Багабанди | Ж.Гомбожав | Шийдээгүй |
|------------|-----------|-------------|------------|-----------|
| 1997.04.13 | 24, 7 % | 46, 0 % | 8, 9 % | 20, 4 % |
| 1997.04.20 | 25, 8 % | 53, 0 % | 7, 3 % | 13, 9 % |
| 1997.04.27 | 30, 0 % | 50, 3 % | 6, 1 % | 13, 6 % |
| 1997.05.04 | 36, 1 % | 47, 0 % | 5, 6 % | 6, 5 % |

Сонгогчдын дунд Н.Багабандийн дэмжигчдийн тоо ийнхүү нэмэгдсэн нь МАХН-ын нэр хүнд өсөж, түүний сөрөг хүчний үүргийг улам олон иргэн хүлээн зөвшөөрч эхэлсэнтэй хэлбоотой. Ардчилсан Холбооны дотоод нөхцөл байдал, түүний маргаан бүхий нэр дэвшигч П.Очирбат нар нь сонгогчдын саналаа тодорхойлоход сөргөөр нөлөөлж байна. Ерөнхий сайд М.Энхсайхан захиран тушаах арга барилаасаа болж өөрийн талынхны дунд хүчтэй шүүмжлэлд өртөж байлаа. АХ-ны зүтгэлтнүүд түүнийг хүмүүсээ үрж байна хэмээн ил тодоор шүүмжилж, гадаадад зардал ихтэй айлчлал хийх дуртай болсон гэж байв. Далдуур түүний залгамжлагчаар Д.Ганболдыг томилохоор ярьж байлаа. Засгийн газраас импортын татварыг бууруулсан нь ширүүн маргааны бай боллоо. Засгийн газрын энэ шийдвэр нь төрөөс нийгэм хангамжийн салбарт асар том таналт хийж байх үед 10 орчим тэрбум төгрөгийн татварын орлогыг устгасан билээ.

Энэ бүхнээс харахад Н.Багабанди сонгуульд ялалт байгуулах нь гэсэн магадлалыг төрүүлж байсан ч нийт саналын 60.8 хувиар (харьцуулбал: П.Очирбат 1993 онд 57.8 хувиар ялсан) ялна гэж хэн ч төсөөлөөгүй юм.

Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн МАХН-ын хувьд улс төрийн эрх мэдлийг эргүүлэн олж авах замд нь чухал шалгуур болсон байна. Парламентад цөөнхийн хориг тавих эрх, Ерөнхийлөгчийн хориг тавих эрх зэрэг нь улс төрийн өрсөлдөгчтэйгээ тэмцэх сонирхолтой хэд хэдэн хувилбарыг үүсгэсэн юм. МАХН-ын 3 дугаар Бага хурлаас Н.Багабандийг Ерөнхийлөгчийн үйл ажиллагаатай холбоотой хууль цаазын үндсэн дээр намын даргын албан тушаалаас чөлөөлж, 98 хувийн саналаар Н.Энхбаярыг залгамжлагчаар нь сонголоо. Өмнө нь сайдын алба хашиж байсан Л.Энэбиш МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга боллоо. Үүний дараагаар МАХН нь бусад сонгууль, нөхөн сонгуульд амжилт гаргаж чадсан билээ. 1997 оны 8 дугаар сарын 17-нд сонгуулийн 21 дүгээр тойрогт (Завхан аймаг) 72.6 хувиар УИХ-ын гишүүнээр сонгогдсон юм. Сонгуулийн 37 тойрогт (Төв аймаг) шинээр сонгууль явагдахад

²⁴ Маш нууц, №7 (1997 оны 5 дугаар сар)

МАХН-аас нэр дэвшсэн Ц.Өөлд 63.5 хувиар ялалт байгуулж УИХ-ын гишүүнээр сонгогдлоо. Сонгуулийн тойргуудыг нийлүүлэх (сумдад), шинээр үүсгэхтэй холбоотойгоор 1999 оны 6 дугаар сард явуулах шаардлагатай болсон орон нутгийн сонгуульд МАХН итгэл төгс ялсан байна. Анхан шатны тогтолцоо, тэдгээрийн ажлыг хадгалан үлдсэн, намаас малчдын ашиг сонирхлыг дэмжих болсон нь МАХН хөдөө орон нутагт улс төрийн сонгуульд ялалт байгуулах үндэс суурь болж өгсөн.

МАХН улс төрийн өрсөлдөгчтэйгээ тэмцэхдээ

МАХН-ын удирдлага АХ-г өрсөлдөгчөө хэмээн үзэж, улс төрийн эрх мэдлийг эргүүлэн олж авах зорилготой болохоо үгүйсгэж байсангүй. МАХН-ын удирдах зүтгэлтнүүдийн санаачилга АХ-ны 1996 онд өргөн хүрээтэйгээр явуулсан албан тушаалын халаа сэлгээгээр тодорхойлогдож байсан нь нууц биш юм. Гэхдээ МАХН улс төрийн тэмцэл явуулахдаа гагцхүү ардчилсан тогтолцооны арга барил, боломжийг ашигласан болохыг мартаж болохгүй. Монголд өнөөгийн байдлаар ардчиллын үнэ цэнэ, ач холбогдлын талаар маргаж байгаа боловч улс төрийн намуудын аль нь ч ардчиллыг зарчмын хувьд үгүйсгээгүй юм.

МАХН-аас АХ-ны Засгийн газрын шийдвэр бүрийг шүүмжлэлтэйгээр дүгнэж эхэллээ. Засгийн газарт ойр байдаг хэвлэл мэдээллийнхэн МАХН-г эсэргүүцсэн маягаар хандах нь нэмэгдсэн тул парламентийн танхим олон нийтийн дунд үр нөлөөтэй, өдөр тутмын хэвлэлд суурилсан тэмцлийн гол талбар болж хувирлаа. МАХН-ын бүлэг Н.Энхбаярын удирдлага дор их зүйл сурах чадвартайгаа харууллаа. МАХН нь богино хугацаанд улс төрийн сөрөг хүчний арга хэрэгслийг эзэмшлээ. Засгийн газрын гишүүд, хувийн компаниудын хооронд нягт холбоо тогтсон байсан тул жишээ нь Ерөнхий сайд М.Энхсайхан маргаан будлиантай гэх “Цагаан шонхор” компаний ашиг сонирхлын төлөөлөгч гэж тооцогдож байсан. АХ-ны төлөөлөгчдийн хувийн ашиг сонирхол хөөцөлдөж байгаа талаар мэдээ сэлт олж авах, эсхүл зохих хувилбарыг бий болгож парламентад гаргаж тавих нь хэцүү биш байлаа. Албан тушаал хөөцөлдөх, АХ-ны удирдлага дахь эрх мэдлийн төлөөх тэмцэл нь өдөр тутмын сонинг дүүргэж байв. Гэвч Б.Дэлгэрмаа зэрэг АХ-ны бүлгийн гишүүд өөрийн талын алдаатай үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах нь ихэслээ. Б.Дэлгэрмаа нь АХ-ны бүлгийн “сахилга бат, ажлын хандлагад санаа зовж” байгаа талаар ярьж,²⁵ Засгийн газрын гишүүд Засгийн газрын ажилтай болмогцоо намын ажлыг бүрмөсөн хаядгийг шүүмжиллээ. АХ-ны бүлгээс гарч буй шүүмжлэлт мэдээлэл нь иргэдийн нүдэнд сөрөг хүчний баримтуудын баталгаа болж байлаа.

²⁵ Ардын Эрх, 1997.03.12.

МАХН-ын удирдлага АХ-н дахь хүчний хуваарилалтыг эртнээс ажиглаж, дүгнэж байсан юм. АХ нь нэгэн цул биш болохыг тэд аль эрт таньжээ. Ялангуяа МСДН-ын гишүүдийн дунд энэ эвсэлтэй социал-демократ гэсэн тодорхойлолтоо хэрэгжүүлж чадах эсэхэд эргэлзэгчид цөөнгүй байлаа. МАХН-ын шинжээчид эдгээр маргааныг улс төрийн хэрэгсэл болгох боломжтойг таньж, ялгавартайгаар хандах нарийн бодлого явуулж эхэллээ. Намын дарга Н.Энхбаяраас сэтгүүлчид “санамсаргүй байдлаар” МАХН, МСДН-ын нэгдэх боломжийн талаар асуух боллоо.

Н.Энхбаяр энэ асуудалд ихэд нээлттэй хандаж байв. Тэрээр нэгэн прициплагадаа: “Эвслийн болоод МАХН-ын удирдлага, лидерүүдийн хүмүүжил, өссөн орчин, олсон боловсрол, ертөнцийг үзэх үзэл, эрхэмлэж ордаг үнэт зүйлсийн тухай ойлголт нилээд ойролцоо... Ойролцоо үзэл баримтлалтай намууд нэгдэх, эсвэл нэг эвсэл болох үйл явц хүссэн хүсээгүй өрнөнө. Үүнд аль намын удирдлага хийгээд гишүүд сэтгэл санааны хувьд бэлэн байх ёстой. Хоёр нам нэгдэхийг үгүйсгэж, ийм аргаар хэзээ ч болохгүй гэж хэлэх нь хариуцлагагүй хэрэг... МАХН МСДН-тай нэг эвсэл болж, ижил төстэй үзэл баримтлалынхаа үндсэн зарчмаар улс орноо хөгжүүлэх ажилд хамтран зүтгэе гэвэл бид бэлэн. Гэхдээ мэдээж хэрэг намын удирдлага бэлэн гэж хэлэхээс гадна гишүүдийн санаа бодол, нийгэм, улс төрийн өнөөгийн байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө шүү дээ. Зарчмын хувьд асуудалд бэлэн л байх ёстой. Өнөөдөр удирдлагын хэмжээнд бэлэн байна гэж хэлэх байна.”²⁶ гэжээ. Гэвч Н.Энхбаярын хэлсэн үгнээс “хөгшин хатагтай” МАХН нь МСДН-тай эвсэл байгуулбал гагцхүү “дүү”-гээр хүлээн зөвшөөрөх нь ойлгогдохоор байсан.

Эрч хүчийн хувьд улам нэмэгдсээр байсан МАХН-ын “тэврэх” брэндлогууд АХ-ны удирдлагад үл итгэх байдлыг төрүүлсэн бололтой. Эвсэл дэх ашиг сонирхлын бутрал, түүнчлэн МСДН-ын нөлөө бүхий зүтгэлтнүүд МАХН-тай ойртохоос буцахгүй байгаа нь тэднийг түгшээж эхлэв. АХ-н дотор буюу уг цөм нь болох МҮАН-д МСДН, МҮАН-ыг нэгтгэх талаар бодож эхлэв. Ийм замаар АХ-н дахь хүчийг нэгтгэхийг зорьж байлаа. МҮАН, МСДН-ын дарга нар болох Ц.Элбэгдорж, Р.Гончигдорж нар 1998 оны 3 дугаар сарын 2-нд өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн урианд гарын үсэг зурлаа. Энэхүү урианд: “Одоогоос хоёр жилийн өмнө хулгана жилийн шинийн нэгний билэгт сайн өдөр МҮАН, МСДН хамтарч “Ардчилсан Холбоо” эвсэл байгуулснаа зарласан билээ. Манай хоёр нам, түүний гишүүд дэмжигчид нийгэм, эдийн засгийн хуучин тогтолцоог

²⁶ Н.Энхбаяр, МАХН, МСДН-тай нэгдэхэд бэлэн байна, Ардын Эрх, 1998.01.19.

өөрчилж, шинийг бүрэлдүүлж бэхжүүлэхийн төлөө байнга хамтран ажиллаж ирлээ. МҮАН, МСДН-ын "Ардчилсан Холбоо" эвсэл бодлого зорилгоо хэрэгжүүлэх эрхээ сонгогч түмнээсээ авч идэвхтэй ажилласны үр дүнд улс орны нийгэм, эдийн засгийн байдал тогтворжиж байна. Тус хоёр намын удирдлагын хувиар бид намын хамт олныхоо ололт амжилтыг дүгнэж үйл ажиллагааных нь хэтийн төлөвийг цэгнэсний үндсэн дээр МҮАН, МСДН нэгдэж, улс төрийн нэг хүчин болж төлөвших нь зүйтэй хэмээн үзэж байна. Манай хоёр намын нэгдэхийн утга учир нь улс орныхоо хөгжил дэвшлийн тогтвортой байдлыг хангах ард түмнийхээ сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг баталгаажуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааныхаа бүтээмжийг улам нэмэгдүүлэхэд оршино гэж бид үзэж байна."²⁷ гэжээ.

Мөн өдөр МСДН-ын "Чөлөөт ардчилсан жигүүр"-ээс хэвлэлд хоёр намын удирдагчдын санаачилгаас татгалзсан мэдэгдэл нийтлүүлжээ. Мэдэгдэлд хоёр нам болоод парламентын бүлэг нь "улс эх орныхоо хөгжлийг хурдасгахад зоримог шийдэмгий үр дүнтэй ажилласныг" хүлээн зөвшөөрсөн ч, хамтын ажиллагааны зарчмыг анхнаасаа тодорхойлоогүй байснаас хоёр намын хооронд "зөрчилдөөн" үүсч байсан талаар гомдоллосон байлаа. Эдгээр зөрчил нь намуудын нэр хүнд, тэднээс хэрэгжүүлж байсан бодлого, эцэстээ сонгогчдын итгэлд сөргөөр нөлөөлсөн. "Чөлөө ардчилсан жигүүр"-ийн төлөөлөгчид: "Эвслийн намууд үр бүтээлтэй хамтран ажилласнаар төлөвлөсөн бодлогоо хэрэгжүүлж, улс орныхоо нийгэм, эдийн засгийг тогтворжуулан өсөлт гаргах нэн хариуцлагатай үед намуудын дарга нар улс төрийн итгэлцлийг эвдэхүйц бодлогогүй алхам хийсэнд гүнээ харамсаж байна... Ийнхүү намуудын зохиомол нэгдлээр асуудлыг хялбар шийдчих мэт хандах нь нийгэмд өөрсдийн байр сууриа эзэлсэн, тодорхой үзэл баримтлалтай намуудын хувьд хэт түргэдсэн үйл явдал юм."²⁸ гэжээ.

Хэд хоногийн дараагаар МСДН-ын улс төрийн зөвлөл хуралдаж, намын дарга нарын уриаг "хүлээн авах боломжгүй" гэж үзлээ. МСДН-ын гишүүд ширүүн маргаж байлаа. Тэдгээрийн олон нь МҮАН-аас тэднийг нэгтгэх гэсэн оролдлогыг нууцаар шүүмжилж байв. Олон нийтэд дэгдсэн маргаан нь АХ-ны хувьд сөргөөр нөлөөлж эхэллээ. "Монгол Ньюс" компаний ерөнхий захирал Ц.Балдорж, МСДН-ын тухай олон хүний бодож байсныг тодорхойлов: "... Монголын улс төрд зонхилох байр суурь эзэлж байгаа хоёр нам хоорондоо гэнэт нэгдэнэ гэдэг үзэл баримтлал байхгүй байсантай холбоотой юм уу даа."²⁹ гэж дүгнэсэн

²⁷ Улс төрийн сенсаац, Засгийн газрын мэдээ, 1998.03.02

²⁸ Мэдэгдэл, Засгийн газрын мэдээ, 1998.03.02

²⁹ Улс төрийн сенсаац, Засгийн газрын мэдээ, 1998.03.12

байна. МАХН-ын удирдлага тайвширч болохоор боллоо. Удирдлагын гишүүн Ө.Энхтүвшин тайлбартаа: "Сүүлийн үеийн байдлаас харахад МҮАН, МСДН хоорондоо нэгдэж чадахгүй юм шиг байна. МСДН-ын Улс төрийн зөвлөл нь тус хоёр намын удирдагч нарын уриалгыг дэмжихгүй гэсэн шийдвэр гаргачихлаа. Ер нь Социаль Демократ Нам бол аль нэг тал руугаа баттай орох ёстой. Одоогийн байдлаар хамгийн хүнд зам туулж байгаа нам бол МСДН юм. Аль ч улсад аваад үзсэн социаль демократ нам зүүний чиглэлийнх байдаг. Гэтэл хэт барууны намтай ижилсээд МҮАН-д "наалдчихсан" байдаг. Үүнээсээ болоод зөрчилд орж, тэр нь өнөөдөр гүнгийрч байна. Гэгэхлээр энэ намын хувьд замаа тодруулах асуудал зайлшгүй тулгарч байгаа юм."³⁰ гэжээ. Ө.Энхтүвшин үүнийхээ хажуугаар "санамсаргүйгээр" МАХН-аас салж Коммунист нам байгуулах зорилготой хүмүүд уг намд байгаа болохыг дурьдсаныг тод дохио гэж үзэж болно. Харим социал-демократууд МАХН-д элсэхгүй байсан нь түүнд урьдын адил коммунист бүлэглэлүүд байсантай холбоотой.

МҮАН, МСДН-ын дарга нарын санаачилгыг тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас авч үзэхэд зөв зүйтэй боловч, зүүний чиг баримжаа бүхий намын хувьд МСДН-ын нэр хүндэд учирсан улс төрийн хохирлыг бараг засахын аргагүй болсон юм. МСДН-ын удирдлага үүний үр дүнд УИХ дахь намынхаа бүлгийн ажлыг гадна талаасаа АХ-ны бүрхүүлийг хэвээр хадгалсан ч арай бие даасан байдлаар явуулахад хүрсэн юм. Түүнд МАХН-ын өмнө зүүний чиг баримжаатай намын дүрийг эсгэхэд улам бүр хэцүү болж байлаа. Цаашид бүр "баруун тийшээ" хазайчихсан тухай "сэжиг" төрүүлэхгүйн тулд МАХН-тай удаан, үл анзаарагдам байдлаар зэрэгцэх зогсох шаардлагатай боллоо. Энэ зорилгыг МАХН-ыг Социалист Интернациональд /СИ/ элсүүлснээр үл анзаарагдах байдлаар хэрэгжүүлж болох байлаа. МАХН-ын дарга Н.Энхбаяр 1997 оны 7 дугаар сарын эхээр Лондонд, СИ-д элсэх тухай намынхаа өргөдлийг өгөхөөр айлчиллаа. Гэвч МАХН эхэндээ ихээхэн бэрхшээлтэй тулгарлаа. Бямбажаргал зэрэг МСДН-ын зүтгэлтнүүд МАХН-ыг элсүүлэх асуудалд хориг тавих эрхээ ашиглажээ. Бямбажаргал Ю.Цэдэнбалыг МАХН-д эргүүлэн элсүүлснийг шүүмжилж, намын архив гэх мэт МАХН-ын хөрөнгийг гаргаж өгөхийг шаардлаа.³¹ Гэвч МСДН-ын зүтгэлтнүүдийн байр суурь алхам алхамаар хатуу байдлаа алдсаар байлаа. МАХН-ын Социалист Интернациональд элсэх хүсэлтийг МСДН зэрэгээр хүлээж авах нь ихэссээр байв.

³⁰ Нам нэрээ сольж байгаа нь төрөл арилжиж буй хэрэг биш, Засгийн газрын мэдээ, 1998.03.11

³¹ Б. Ханддолгор, МАХН-ыг судлах үүрэг МСДН-д ноогдсон, Ардын Эрх, 1997.11.21

1998-99 онуудад МАХН-д бусад намууд, ялангуяа МУНН, МАН зэрэг үндэсний ардчилсан хүрээний намууд улам ихээр татагдах болж, МАХН тодорхой нас, нийгмийн бүлэглэл дахь нөлөөгөө тэллээ.

МАХН-ын улс төрийн эвсэл, сүлжээ, нийгмийн хүрээ

Монголын Уламжлалын Нэгдсэн Нам нь 1993 оны 12 дугаар сарын 5-нд Монголын Хувийн Өмчтөний Нам, Монголын Малчин Тариачдын Нэгдсэн Нам болоод Монголын Тусгаар Тогтнолын Намууд нэгдснээр үүссэн юм. Энэ нам 1994 онд Улсын Дээд Шүүхэд бүртгүүлж, тухайн үедээ 12.000 гишүүнтэй байлаа. Эдний хамгийн тод томруун хүн нь удаан хугацааны туршид яах аргагүй УИХ-ын цорын ганц төлөөлөгч болох зохиолч бөгөөд олон хүний үзэж байснаар гал халуун эх оронч гэгдсэн О.Дашбалбар байсан билээ. Дашбалбар нь нарийн түвэгтэй зан авиртай, энгийн үнэлэмжээр хэмжиж болохооргүй хүн байсан боловч, түүний бичиж, ярьж байсан зүйлс нь Монголын ард түмний сэтгэлийн илрэл болж байсан тул хүн амд тодорхой байдлаар хүрч байсан юм.

Монголын Ардын Нам 1991 онд 2000 орчим гишүүнтэйгээр байгуулагдаж, 1992 онд Улсын Дээд Шүүхэд бүртгүүлжээ. Намын дарга нь олон жилийн хугацаанд Д. Баасан лам байв.

Энэ намуудын хооронд ихээхэн ялгаа байсан ч энд дурьдахаа больё. Эдгээр намууд нь аль аль нь уламжлалыг баримтлагчдын урсгалд хамаарч байсан агаад Монголын нийгэмд нэг намаас хэтэрсэн хүрээтэй байжээ. Энэ урсгалыг зүүн, баруунд хамааруулж тодорхойлох боломжгүй байсан тул нилээд ээдрээтэй мэт санагдаж болох. Тэдний үзэл бодол дотроосоо ч, гаднаас ч /жишээлбэл Далай лам, бүс нутгийн үзэлд үндэслэсэн улс төрийн бусад чиг, урсгалууд/ тэжээгдэж байсан бөгөөд хүн амын бүх давхаргад үндэслэж, нэг талаас шарын шашинг баримтлагчид, эх орончид, сэхээтнүүд, нөгөө талаас хөдөөний уламжлалыг баримтлагч иргэдийн хооронд нэг ёсны гүүр болж байлаа.

Хэсэг хугацааны дараа МАХН-ын дарга Н.Энхбаяр энэ урсгалын хаана ч хүлээн зөвшөөрөгдсөн төлөөлөгч болж чадсан юм. Тэрээр Монголын Орчуулагчдын Холбооны Дэд Ерөнхийлөгчийн хувьд дээрх урсгалд хамаарах хэсэг бүлэг сэхээтнүүдийн төлөөлөл байсны хувьд энэ ажилд хэнээс ч илүүтэйгээр тохирч байсан. Энэ утгаараа шаардлагатай хүмүүсийн сүлжээтэй холбоо тогтоож, Гандан хийдтэй нягт холбоотой байжээ. 1992-оос 1996 онуудад П.Жасрайн Засгийн газарт Соёлын сайдын албыг хашиж байх үе шарын шашны төрийн шүтээн Мэгжид Жанрайсэгийг бүтээх гол санаачилга түүнээс гарч байв. Н.Энхбаяр хэлэхдээ 1982 оноос багш шавийн барилдлагатай болсон /энэ хүн нь хэн бэ?/ гэж хэлсэн байдаг бөгөөд өөрийгөө Далай лам, Бакула Ринбучи,

Гүрдаваа Ринбучигийн шавь хэмээн нэрлэж байсан юм.³² Энэтхэг улсаас Монгол улсад сууж байсан элчин сайд Бакула Ринбучи өөрөө түүнд "Бурхан багшийн сургаал" номыг монгол хэлнээ хөрвүүлэх саналыг тавьж байсан гэдэг. Орчуулгын хэл зүйн редакцийг О.Дашбалбар хийх болсон нь эдгээр улс төрчдийн хоорондын үзэл бодол маш ойролцоо байсныг илтгэх мэт.

Н.Энхбаяр болоод МАХН Монголын шарын шашинд өөрийг нь хүлээн авч үр нөлөө нь нэмэгдэж байна гэж үзэж болохоор боллоо. Жамба лам Чойжамцаас МАХН-ыг дэмждэг нь үнэн эсэх, энэ нь лам түүнд хир тохирч байгаа талаар асуухад: "Монголын Бурхны шашны холбоо" болоод шарын шашны номч лам нар нь манай улс орон, ард түмэнд тустай зүйлийг бүтээж, хэрэгжүүлж байгаа ямар ч нам, төр, олон шийтийн байгууллагыг дэмждэг"³³ гэсэн байна.

1999 оны 3 дугаар сарын 1-нд буюу МАХН байгуулагдсаны 78 жилийн ойн өдөр /1925 хүртэл Монголын Ардын Нам /МАН/ нэртэй байсан/ МАХН, МУНН нэгдэх буюу МУНН өөрийн 8.300 гишүүнтэйгээ МАХН-д нэгдэн орлоо. Энэхүү нэгдэл нь асар том бэлэг тэмдэг төдийгүй, тодорхой чиглэлд дохио илгээсэн хэрэг мөн. МАХН нь хөтөлбөрийн хүнд социалист зорилготой байсан боловч, улс төрийн практик ажилдаа өөрийгөө эдгээр гишүүдэд нээхэд бэлэн үндэсний ардчилсан нам гэж ойлгож байлаа. Түүнээс өмнөхөн буюу 1999 оны 2 дугаар сарын 27-нд Монголын Коммунист Нам Улсын Дээд Шүүхэд бүртгүүлсэн явдлыг учир мэдэх хүмүүсээс нам доторхи тодорхой бүлэглэлд илгээсэн дохио гэж үзсэн байдаг. Эдгээр гишүүд нь Зөвлөлтийн үеийн МАХН-ын коммунист байр суурийг сэргээхийг зорьж байсан юм. Эдгээр нь Н.Энхбаярыг тойрсон шинэчлэгчдийг бүтээхээр зэхсэн орчин үеийн социалист намын дүр зурагт таарахгүй болсон байв. МАХН-ын одоогийн чиг шугамд

³² Бакула Ринбучи, 1917 оны 5 дугаар сарын 18-нд Кашмирийн Жаммуд төрсөн, Путубын хийд, Лхаст бурхны шашны шинжлэх ухаанд суралцсан, 1951-1967 онд парламентийн гишүүн, Энэтхэгийн Кашмирт сайд, 1967-1970, 1971-1977 онуудад Энэтхэгийн парламентийн доод танхимд гишүүн, Улаанбаатар хотод байрлах Энх тайваны төлөөх Дэлхийн Буддистуудын Бага Хурлын Дэд Ерөнхийлөгч, Бакула гэгээний 20 дахь хойд дүр, Найдан хувилгааны 16 дахь хойд дүр, 1990 оноос Энэтхэг Улсаас Монгол Улсад суух элчин сайд. Гүрдаваа Ринбучи, Өвөр Монголын Ордос нутгийн хүн, Гүмбүм, Лаврин, Баруун зууд бурхны шашны шинжлэх ухаанд суралцсан, Далай ламын хамтаар Лин Ринбучи, Лэчин Ринбучи нараар ном заалгасан, 1947 оноос хойш Балбад амьдрах болсон

³³ Би хүнд машин бэлэглэх тийм баян хүн биш, Өдрийн Сонин, 1999.05.28

таарахгүй байгаа хэн боловч Коммунист Намд элсэх зам нь чөлөөтэй болсон байжээ.

МАХН, МУНН нэгдсэн нь МАХН-ын удирдлага үзэл бодлын хувьд ойролцоо хоёр намыг дээрээс захиран тушаахгүйгээр нэгтгэх боломжтой болохыг АХ-ны удирдлагад харуулсан юм. МАХН өөр бусад намтай нэгдэхийг тэр үед үгүйсгэх аргагүй байсан ч, олон намуудын бутархай байдал нь МАХН-д ашигтай байсан тул ийм нэгдлийг 2000 оны сонгуулиас өмнө хэрэгжүүлэхгүй гэдэг нь тодорхой байсан юм.

1999 оны 5 дугаар сард Монголын Бүгд Найрамдах Нам /Намын дарга Б.Жаргалсайхан/, Монголын Сэргэн Мандлын Нам /Намын дарга Л.Дашням/ нэгдэж Б. Жаргалсайханы удирдлага дор Монголын Бүгд Найрамдах Намыг байгуулав. Намын хоёр дарга өөрийн хөтөлбөрийн агуулгыг "Монголын ард түмний язгуур эрх ашиг" хэмээн тодорхойлж байв. Б.Жаргалсайхан, Л.Дашням нар хоёулаа МАХН-тай хамгийн багаар бодоход элгэмсүү, чөлөөтэй харьцаатай байв.³⁴

МАХН уламжлалыг баримтлагчдыг илтэд дэмжихийн сацуу Монголын ард түмний уламжлал, ёс заншлийг хүлээн зөвшөөрч албан ёсны бус зохих бүтцүүдийг дэмжихээ илэрхийлэв. Энэ хүрээнд МАХН-аас жишээлбэл, тухайн үед Монголын 108 хаад, Монголын шарын шашны тэргүүд Жавзандамба хутагт нарын намтар түүхийг бичиж нийтлэх ажлыг гүйцэтгэж байсан "Хаадын сан"-ийн үйл ажиллагааг дэмжиж байлаа.³⁵ Н.Энхбаяр энэ сангийн ажлыг тодорхойлохдоо: "Монгол орон төрийн олон зуун жилийн уламжлалтай. Манай намын бүлэг УИХ-ын үйл ажиллагаанд оролцохдоо ч энэ талаар ямагт цохон тэмдэглэж байдаг юм. Монгол төрийн энэхүү баялаг уламжлалыг манай эрдэмтэн, түүхчид бичсэн ном зохиолдоо өгүүлсэн байдаг. Хаадын сан Монголын хаад, богд нарын тухай 108 боть ном бүтээж байгаа нь төрийн уламжлалын гинжин холбоог үргэлжлүүлж байгаагийн илрэл, хойч үеийнхэнд нэн өгөөжтэй сайхан үйлс мөн гэж МАХН үзэж байна."³⁶ гэжээ.

МАХН 1996 онд болсон УИХ-ын сонгуулиас бүр өмнө залуучуудын дунд системтэй ажил явуулж эхэллээ. Намын удирдлагаас 1994-1995 онуудад анх удаа тус орны залуучуудын байдал, тэдний нийгэм дэх байр сууринд дүн шинжилгээ хийж эхэлсэн юм. 1994-1995 оны үед нийт хүн

³⁴ Өдрийн Сонин, 1999.05.22

³⁵ Энэ Сангийн тэргүүнээр Н.Дугарсүрэн, Сангийн Удирдах Зөвлөлийн дарга нь НИК концерний Дэд Ерөнхийлөгчөөр Б.Сүхбаатар, Сангийн Удирдах Зөвлөлийн ахлах редактороор Үнэн сонины ахлах редактороор ажиллаж байсан Л.Түдэв нар ажиллаж байна.

³⁶ Монголчууд хаадынхаа түүхийг уншиж эхэллээ, Үнэн, 1999.07.08

омын 71, 85 хувь нь 10-35 насны хүүхэд, залуучууд байсан гэж үзвэл, энэ насныханд анхаарал хандуулах нь Монгол дахь улс төрийн намд ямар ч холбогдолтой болох нь тодорхой. Тэр байтугай тухайн үед МАХН-ын 20 000 гишүүн энэ насныхан байжээ. Залуучуудын дунд явуулах ажлыг эрчимжүүлэх үүднээс, залуу гишүүд, дэмжигчдийн Анхдугаар хурлаас 1994 оны 6 дугаар сарын 8, 9/ "МАХН-ын залуу гишүүд, дэмжигчдийн зөвлөл"-ийг байгуулжээ. Энэхүү зөвлөлөөс нийслэл Улаанбаатар, 21 аймагт сүлжээний бүтцийг бий болгов. Практик ажил дээрээ энэ зөвлөл нь МАХН-ын тогтолцоог ашиглах боломжтой байв. 1997 оны 9 дүгээр сард уг зөвлөлөөс Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбоо /МАСЭХ Ерөнхийлөгч У. Хүрэлсүх/, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул, Сүхбаатар, Төв аймгууд дахь болоод 1998 онд Дорнод, Говь-Алтай, Өвөрхангай, Говь-Сүмбэр, Дорноговь, нийслэлийн Баянгол, Налайх дүүргүүд дэх салбар, Багануурт салбарууд үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, энэ үед оюутан залуусын "Тэмүүлэл" хөдөлгөөнийг үүсгэн байгуулав.³⁷

1994 оноос МАХН-аас тус орны эмэгтэйчуудын дунд ажил эрэгжүүлж эхлэв. Эмэгтэйчүүд нь сонгогчдын томоохон нөөц байгаад догсохгүй, хэдийгээр тухайн үедээ Монголын нийгэмд эрэгтэйчүүдээсээ илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэж байсан хэдий ч, нийгмийн шилжилтийн үед хохирч үлдсэн хэсэг нь байсан билээ. МАХН-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, түүхч Д.Алтайгаар удирдуулсан "Эмэгтэйчүүд-Хөгжил" хөдөлгөөн нь богино хугацаанд эмэгтэйчуудын эрх ашгийг дорвитой төлөөлөх боллоо. Үүний сацуу уг хөдөлгөөн нь ДОХ-ын эсрэг тэмцлээрээ оюутнуудын дунд нэр хүнд олоод байв. Хөдөлгөөний гишүүд 1998 оны 5 дугаар сарын 5, 6-ны өдрийн 2 дугаар хурлаар залуучуудын хөдөлгөөнтэй адилаар Монголын Ардчилсан Социалист Эмэгтэйчүүдийн Холбоо /МАСЭХ, Ерөнхийлөгч Д.Алтай/ байгуулах шийдвэр гаргалаа. Энэ холбоонд байгуулагдсанаас нь хойш 5.000 гишүүн элссэн агаад оюутан бүсгүйчүүдийн "Шинэ үе" клубыг байгууллаа.

МАХН-ын дарга Н.Энхбаяр үүнтэй зэрэгцээд Үйлдвэрчний Эвлэлүүдтэй харилцаагаа эрчимжүүллээ. Эдгээр нь сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжилтэй зэрэгцэн алхаж чадахаа больж үндсэндээ амьтай галтай төдий л болсон байлаа. Монголд өмнөх социализмын үеийнх шиг үйлдвэрчний эвлэлийн маягаар зохион байгуулагдсан ажилчдын хамт олон үндсэндээ үгүй болжээ. Шинэ салбаруудын Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны даргатай 1997 оны 11 дүгээр сард уулзаж байхдаа Н.Энхбаяр нийгмийн халамжийг эрхэм зорилгоо болгодог

³⁷ МАХН-ын хэвлэл мэдээллийн албаны мэдээлэл, 1997, 19-р нүүр

зүүний чиг баримжаат аливаа хүчнүүд үйлдвэрчний эвлэлүүдтэй хамтарч ажиллах ёстой гэдгийг тэмдэглэжээ. Үйлдвэрчний эвлэлүүдийн нөлөө бодит нөлөө ямар хэмжээтэй байж ирснийг тодорхойлоход бэрхшээлтэй ч намын даргын энэ үг нь нийгмийн халамжийн талаарх МАХН-ын чармайлтыг олон нийтэд ил тод байхаар илэрхийлжээ.

Бусад намын хувьд үйл ажиллагаа нь хотын хүн амын асуудалд голлон анхаарч байсан бол МАХН-ын өөрийн улс төрийн мэдлэг боловсрол, хүчин чармайлтыг үргэлж хөдөөгийн хүн ам, түүн дотроо нийгмийн том бүлэг болох малчдад чиглүүлсээр ирсэн. Ингэхдээ нийгмийн энэ бүлгийн өргөн хэсгүүдэд ядуурал газар авч байсанд гол анхаарлаа төвлөрүүлсэн байна. Статистикийн Төв Газрын мэдээллээс үзэхэд 1997 оны байдлаар малчдын 45, 6 хувь ядууралд автаад байсан бөгөөд мал сүргийн ихэнх нь нийт малчдын 20 хувьд төвлөрч байжээ.³⁸

Ингээд МАХН-д нийгмийн чухал насны хүмүүс, тодорхой бүлгүүдэд өөрийн байр сууриа олоод зогсохгүй эдгээрийг сүлжээний бүхэл бүтэн тогтолцооны тусламжтайгаар улс төрийн намын сонирхолтойгоо холбож чадлаа. Үүнээс гадна боловсон хүчин бэлтгэх механизмыг /сургалт, семинар/ бүрдүүлж, үүнийг дагаад зохион байгуулалтын /шинэ гишүүдийг бүртгэх шинэ тогтолцоо, нягтлан бодох бүртгэлийн шинэ систем/ чухал арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, нийгэм, улс төрийн дүн шинжилгээний /дүн шинжилгээний "Прогноз" төв/ ач холбогдол нэмэгдсэнийг тэмдэглэх хэрэгтэй.

АХ-ны түр Засгийн газрууд

1998 оны 4 дүгээр сарын 22-нд Ерөнхий сайд М.Энхсайхан Засгийн газраа огцорсныг мэдэгдлээ.³⁹ Сөрөг хүчний ёсоор МАХН-аас УИХ-д ийнхүү огцорсныг аль хэдийн хэрэгжүүлэх ёстой байсан юм гэлээ. Хүн амын бодит орлого 30 хувиар буурч, ядуу өрхийн тоо 46 000-аар нэмэгдэж, ядуусын тоо 200.000-аар нэмэгдсэний хариуцлагыг АХ-д тохож байв.

³⁸ У.Б.Баркманн, *Малчдын 67 хувь нь хүүхдээ их, дээд сургуульд сургах боломжгүй, Өнөөдөр, 1999.02.11*

³⁹ М. Энхсайхан нь Сангийн сайд асан П.Цагаан /Голомт банкны захирлаар ажиллаж байсан/, өөрийн эдийн засгийн зөвлөхөөр ажиллаж байсан Ц.Батболд, өөрийн туслахаар ажиллаж байсан Д.Цэвэгдорж нарын хамтаар макро эдийн засаг, банк, санхүү, хууль, зээл, үнэт цаасны зах зээл, хувьчлалын чиглээр зөвлөгөө өгөх „Премьер интернэшнл“ нэртэй хувийн компани байгуулжээ.

1998 оны 4 дүгээр сарын 23-нд Ц.Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилов. Ц.Элбэгдорж нь Львов хотын Зөвлөлтийн армийн Цэргийн Их Сургуулийг дүүргэсэн /хуучин ЗХУ/ бөгөөд АХ-ны удирдлагын идэвхтэн гишүүдийн нэгт тооцогдож байв. Тэрээр өмнөх сайдаас ялгаатай нь, МАХН-д хамаагүй хүлээцтэй хандаж байв. Ерөнхий сайдад томилогдохоос өмнө тэрээр тойрон хүрээлэгчдийн хамтаар МАХН-д хандсан "инээмсэглэлийн довтолгоо" эхлүүлжээ. 1 дүгээр сард МАХН-ын дарга Н.Энхбаярыг "Оны шилдэг улстөрч"-өөр шагнагууллаа. Шагналын хорооноос уг шагналыг "Монголын ардчиллын эцэг" С.Зоригт олгохоор зэхэж байжээ. Гэвч хэдхэн сарын дараа төрийн бэлгэдэл хувийн банкныг нэгтгэсэн маргаантай асуудлаас шалтгаалан Ц.Элбэгдоржийн Засгийн газар огцорлоо. Ингээд зогсолтын үе олон сар үргэлжилж, Монголын ардчилсан хөдөлгөөний тэргүүн С.Зоригийн амийг үл мэдэгдэх этгээдүүд хөнөөсөн өнөөг хүртэл эзэн холбогдогч нь болдоогүй байгаа хэрэг гарч туйлдаа хүрсэн юм. С.Зоригийн амийг улс төрийн зорилгоор хөнөөсөн хийгээд үүнийг санаачлагчдыг АХ-ны ойр орчмоос хайх хэрэгтэй гэсэн цуурхал өнөөдрийг хүртэл хүн амын дотор татардаггүй билээ.

УИХ-ын шийдвэрээр 1998 оны 1 дүгээр сарын 9-нд /МҮАН/ Ж.Наранцацралтийг 63, 2 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхий сайдаар томиллоо. Тэрээр хувь хүний байдлын хувьд тухайн үедээ Ц.Элбэгдоржоос хамаагүй илүү бэлтгэгдсэн нэгэн байсан бөгөөд захиргааны мэргэжилтний хувьд орон нутгийн өөрөө удирдах ёсны бараг бүх шатыг дамжин туршлага хуримтлуулжээ.

Гэтэл Ж. Наранцацралтыг ч хэдхэн сарын дараа огцрууллаа. Эрдэнэтийн уулын баяжуулах зэс-молибдений үйлдвэртэй холбоотойгоор ОХУ-ын тэргүүн шадар сайдад бичсэн захидал түүний улс төрийн "нугасыг хугаллаа".⁴⁰ Ерөнхийлөгч Н.Багабанди хүртэл тэрхүү захиаг огцруулах хангалттай үндэслэл болж байгаа эсэхэд эргэлзэж байгаагаа мэдэгдсэн ч, үүнтэй зэрэгцээд энэ ажил хэрэгт "хамтран оролцсон" талаарх шүүмжлэлийг няцаалаа. Ингээд Р.Амаржаргалыг /МҮАН/ Монгол Улсын шинэ Ерөнхий сайдаар томиллоо. Гэвч тэрээр бас л "түр зуурын" Ерөнхий сайд болох байв.

Ийнхүү огцруулахын үйл явц яг ижил байлаа. Ерөнхий сайдууд бүгд хувийн хэвшилтэй хэт нягт холбоотой байсан бөгөөд, төрийн аппаратын зүгээс зориудаар гаргасан мэдээ мэдээлэлд бүдэрч байлаа. Сөрөг хүчин энэ тутамд "улсын аюулгүй байдалд" аюул учирлаа хэмээж Засгийн газрыг огцруулах тухай асуудлыг тавьдаг байна. Засгийн газар

* Орчуулга

шинээр бүрдэх тутамд АХ-ны боловсон хүчний нөөц нимгэрсээр байгааг харах боломжтой байсан ба АХ-ноос тогтвортой, шинэлэг элитийг бэлтгэж чадаагүй нь тодорхой болж байв.⁴¹ МАХН нь хэдийгээр Засгийн газрыг огцруулахыг шаардаж байсан бөгөөд зарим үед дахин сонгууль явуулах тухай санал гаргаж байсан ч ийм сонгууль явуулах сонирхолгүй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Улс төрийн цаг хугацаа Монголын хувьд МАХН-д ашигтайгаар эргэж байлаа. Сант Марал сангаас Германы Конрад-Аденауэр Сангийн дэмжлэгтэйгээр 1999 оны 4 дүгээр сард 1086 хүний дунд явуулсан санал асуулгын⁴² дүн энэ хандлагыг тодорхой харуулж байна.

Маргааш сонгууль байсан бол Та саналаа өгөх үү? (хувиар)

| | 1998 оны 10 дугаар сар | 1999 оны 4 дүгээр сар |
|------------|------------------------|-----------------------|
| Тийм | 65, 9% | 60, 3% |
| үгүй | 16, 3% | 21, 8% |
| мэдэхгүй | 16, 7% | 16, 5% |
| хариултгүй | 1, 2% | 1, 4% |

**Маргааш сонгууль боллоо гэхэд
Та аль намд саналаа өгөх вэ? /хувиар/**

| | 1998 оны 10 дугаар сар /бүгд/ | 1999 оны 4 дүгээр сар | 1998 оны 10 дугаар сарын /сонгох эрхтэй/ | 1999 оны 4 дүгээр сар |
|--------------|-------------------------------|-----------------------|--|-----------------------|
| МАХН | 40, 9 | 50, 4 | 48, 5 | 62, 8 |
| АХ | 27, 2 | 14, 8 | 29, 3 | 16, 1 |
| Бусад нам | 8, 2 | 8, 3 | 9, 9 | 7, 8 |
| Аль намд биш | 8, 2 | 16, 3 | 10, 3 | 11, 8 |
| Шийдээгүй | 8,0 | 10,2 | 1,8 | 1,5 |

Энэ хандлагын улмаас МАХН олон нийтэд АХ-ны "ёс суртахуун"-ыг шүүгчийн байр сууринаас дүгнэж эхлэх боллоо. Ямар ч тохиолдолд парламентийн гишүүдийн ёс зүйн алдааг хянаж шалгах үүрэгтэй УИХ-ын "Ёс зүйн дэд хороо"-г МАХН-ын гишүүн удирдаж, нийт 14 гишүүний 8

⁴¹ У. Б. Баркманн, Монголын намуудад чанарын хувьд шинэ элитууд гарч ирж чадсангүй, Парламент /Улаанбаатар/, 1999, 2, № 1/31/

⁴² С. Оюун аравт анх удаагаа орлоо, Өнөөдөр, 1999.04.22.

нь МАХН-ын гишүүн болсон нь хэний ч гайхлыг төрүүлсэнгүй.⁴³

АХ-ны Засгийн газруудын үйл ажиллагаанаас хүн амд АХ нь улс орны улс төрийн бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадахгүй болжээ гэсэн сэтгэгдлийг төрүүллээ. Гэвч АХ-ны Засгийн газрууд оршин тогтносоор байх улс төрийн хувьд практикийн тодорхой ашигтай явдал байв. Хэдийгээр Монголын улс төрийн бодлогын үр дүн тэдний урмыг хугалж, зээл тусламжинд болгоомжтой хандах нь зүйтэй байсан ч хандивлагч орнууд тусламжийн гараа урьдынхаасаа ч харамгүй сунгасаар байлаа.

Энэ байдал гэвч энэ хэвээр үргэлжлэх албагүй билээ. Хандивлагчдын тусламж үргэлж цаг хугацааны хязгаарлалтай байдаг. Улс орны аж ахуйд голлох үүрэг бүхий аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын эхний үр дүн гарч, Монголд эдийн засгийн нөлөөгөө урт хугацаанд байршуулж чадсан болох нь илрэх цагт зарим хандивлагчдын өнөөгийн харамгүй зан эсрэгээр эргэнэ. МАХН-ын удирдлага үүнийг сайтар ойлгож байсан юм. МАХН-аас тодорхой бүс нутгийн үзэл санааны тухай эргэцүүлж эхлэн, түлхүүр ач холбогдолтой зарим үйлдвэрийн хувьчлалыг саатуулах санаатай байна уу гэлтэй байлаа. Энд өмнөх МАХН-ын Засгийн газраас "Бүхэлдээ төрийн өмчид буюу ихэнх хувь нь төрийн мэдэлд үлдэх үйлдвэрүүдийн жагсаалт" /1991 оны 6 дугаар сарын 7/ нэртэй 170 дугаар тогтоолын зарим зүйлийг тодорхойлоод заачихсан байсныг тэмдэглэвэл зохино.⁴⁴ Гэхдээ хувьчлалын өнөөгийн явцаас харахад татварын орлого хир тааруу байсаас шалтгаалж Монгол Улс эд хэдэн цомхон улсын үйлдвэртэй байх асуудал тавигдаж байсан.⁴⁵

⁴³ Үс зүйн дэд хорооны гишүүд: Дарга: Ц.Шаравдорж, гишүүд: Ё.Адилбих /МАХН/, С.Баярцогт /МСДН/, Ч.Сайханбилэг /МҮАН/, Т.Ганди /МАХН/, О.Дашбалбар /МУНН/, Р.Сандалхаан /МАХН/, С.Төмөр /МАХН/, Э.Бат-Үүл /МҮАН/, Ч.Дашзэвэг /МҮАН/, Ц.Нямдорж /МАХН/, Н.Батцэрэг /МҮАН/, М.Зэнээ /МАХН/, А.Болат /МАХН/, Өдрийн Сонин, 1999.06.30

⁴⁴ U. V. Barkmann, *Mongolische Republik. Aufstellung der Joint Venture, Staatsbetriebe sowie der Betriebe und Einrichtungen mit dem Recht auf Außenhandel*, Hamburg 1993, S. 11

⁴⁵ Олон улсын зээл тусламжийг улсын эдгээр үйлдвэрт үйлдвэрлэлийн зохих бүтэц бий болгоход чиглүүлж, менежментийг бэлтгэх нь дунд хэмжээний үйлдвэрүүдийн хувьд өнөөг хүртэл хэрэгжүүлж буй „усалгааны“ зарчмаас олон тохиолдолд илүү гэдэг нь харагддаг. Ингэхдээ ердөө анзаарагддаггүй нэгэн хүчин зүйлийг харгалзах хэрэгтэй. Сүүлийн хэдэн арван жилийн туршид Монголд харьцангуй сайн бэлтгэгдсэн боловсон хүчний цөм бэлтгэгдлээ. Хүний энэ үнэтэй нөөц алга болоход хүрээд байна. Япон Улсаас Монголын яамдтай Японд нэг жилийн хугацаатай мэргэжлийн ажилтан бэлтгэх, хоёр жил хүртэлх хугацаагаар сунгах боломжтой байх нөхцөлтэй байхаар тохиролцжээ.

Ерөнхийлөгч хэмээх төрийн эрх мэдлийн төв

АХ-ны Засгийн газрууд улам доройтсоор байхад Ерөнхийлөгч Н.Багабандийн /МАХН/ эрх мэдэл, хүч чадал нэмэгдсээр байн Н.Багабанди нь Ерөнхийлөгчийн албыг улс төрийн шуурган дахь хэдийгээр маргаантай ч тогтвортой байдлын туйл болгож чадсан юм.

1992 оны 1 дүгээр сарын 16-нд батлагдаж, 1992 оны 2 дугаар сарын 12-нд хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн гучдугаар хэсгийн 1-т зааснаар: "Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн" гэжээ. Энэ утгаараа тэрээр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн тэргүүн, Зэвсэгт Хүчний Ерөнхий Командлагч бөгөөд бусад олон чухал бүрэн эрхийг эдэлдэг байна. Энэ бүрэн эрхэд өөрөө хууль санаачилахаас гадна, УИХ-аас баталсан хуульд хэсэгт нь буюу бүхэлд нь хориг тавих эрх хамаардаг байна. Ерөнхийлөгч Н.Багабанди энэ бүрэн эрхээ нилээдгүй хэрэгжүүлсэн байх юм. 1997 оны 6 дугаар сарын 20-ноос 1999 оны 6 дугаар сарын 10-ны хооронд нийт 13 хууль буюу хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг санаачилж, 14 хуульд бүхэлд нь буюу хэсэгт нь хориг тавьсан байна. Үндэсний аюулгүй байдал, голлох үйлдвэрүүдийн хувьчлалын хооронд Ерөнхийлөгчийн хувьд түүнд илэрхий хамааралтай гэж үзэж буйгаа олон тайлбарласан байдаг. Энэ асуудал болоод бусад байдлаар түүний энэ байр суурь УИХ-д МАХН-ын төлөөлдөг тайлбараас зөрдөг байв. МАХН-ын бүлгээс улс орны төсвийн байдлыг харгалзаж, Монголын эдийн засгийн хамгийн "шүүслэг" хэсгүүдийн хувьчлахдаа яарахгүй байхыг Засгийн газарт удаа дараа сануулж байлаа. Гадаадын хөрөнгө оруулагчид /дотоодын хөрөнгө оруулагчид энд барагтай бол төсөөлөгдөхгүй байна/ аливаа аж ахуйн нэгжийг "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуульд⁴⁶ зааснаар хувьчилж авахдаа эхний 3 жил татвараас чөлөөлөгдөж, дараагийн 3 жилд татварын 50 хувийг л төлөхөөр байгаа бөгөөд НИК, Эрдэнэт, Говь зэрэг үйлдвэрүүд хамгийн том татвар төлөгч тул татварын ихээхэн алдагдалд орохоор байна гэжээ. МАХН-аас гаргаж байсан үндэслэлүүд нь уг намын улс төрийн ирээдүйтэй мөн л хобоотой байв. Хүн ам дахь улс төрийн уур амьсгал, бусад намуудын байдлаас харахад 2000 оны сонгуулиар МАХН ялах нь бараг тодорхой болоод байсан юм. 2000 оноос ийм хэмжээний татварын алдагдал хүлээх тохиолдолд улс төрийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар тэд нилээд санаа зовних болсны дээр 2001 оноос 1991 оноос эхлээд гадаадаас авсан

⁴⁶ U. B. Barkmann, *Gesetz über ausländische Investitionen in der Mongolei, Einführung und Übersetzung*, In: *Wirtschaft und Recht in Osteuropa*, 6 (1999), S. 220-224

шилт 528 сая ам.долларын зээл эргэн төлөгдөж эхлэх байв. МАХН-ын бүлгийн байр суурийг эсэргүүцэн, хувьчлалд хамрагдаж буй үйлдвэрүүд олон жилийн өмнө баригдсан, ашгаараа өөрийн боломж, техник технологийн шинэчлэл хийж өргөжүүлэх боломж хязгаарлагдмал тул дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжоо алдахад хүрнэ гэсэн Ерөнхийлөгч Н.Багабандийн анхааруулсан нь яах аргагүй үнэнд нийцнэ.⁴⁷ Энэ үндэслэл нь Ерөнхийлөгч Н.Багабандийн хувьд Монголын эдийн засгийн хамгийн "шүүсслэг" хэсгүүдийн хувьчлалын зарчмын хувьд зөвшөөрч, харин зарим голлох хүчин зүйлийн талаар Зүүн Хойд Азийн бүс нутгийн хөгжил, хүчиллалтай холбоотойгоор авч үзэж байсан бололтой.

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-иас үзвэл /1993 оны 6 дугаар сарын 5/ Ерөнхийлөгч нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг тэргүүлэх чухал үүргийг харгалзахад зарчмын хувьд гадаад бодлого дахь хамгийн гол төлөөлөгч мөн ажээ. Энэ хуулинд: "Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн эрхтэй төлөөлж, мэдэгдэл, хэлэлцээ хийх, хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна."⁴⁸ гэжээ. Ерөнхийлөгч Н.Багабанди 1994 онд УИХ-аас баталсан "Монгол Улсын гадаад бодлогын үзэл санаа"-г гадаад бодлогын стратегийн үндсэн бичиг баримт гэж үздэг болохоо хэзээ ч нуугаагүй. Нэгэн ярилцлагад тэрээр: "Энэ баримтыг Монгол Улсын гадаад бодлогын стратегийн чигийг тодорхойлж нилээд удаан хугацаанд мөрдөхөөр баталсан юм... Гадаад бодлогын анхны гол тулгуур нь Монгол Улс хоёр их хөрштэйгээ найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тэгш хөгжүүлэхэд оршино."⁴⁹ гэсэн байдаг. Энэ асуудлын хувьд Н.Багабанди МАХН, ялангуяа Монголын улс төр дахь уламжлалыг баримтлагч жигүүрийн дэмжлэгийг бүрмөсөн хүлээжээ. Өмнө дурьдаж байсан О.Дашбалбар энэ талаар: "Монголд ашиг сонирхол бий. Энэ нь манай хөрш хоёр их гүрнүүдийн ашиг сонирхлоос хамаарна. Оросын ашиг сонирхол бол Монголын ашиг сонирхол. Монголын ашиг сонирхол бол Оросын ашиг сонирхол. Энэ ашиг сонирхлыг хөндөж болохгүй. Бид Монголын үндэсний эрх ашгийг хамгаалах гэж байгаа бол Оросын эрх ашгийг харгалзан үзэх ёстой. Энэ нь манай тусгаар тогтнолын төлөө юм. Орос 170 сая хүн амтай, Хятад 1,3 тэрбум хүн амтай. Хоолоо тэгэхээр хэнтэй хуваах вэ? Хятад бол их гүрэн. Бид тэдэнтэй хэвийн харилцаатай байхыг хүснэ. Гэвч Хятад ХХI

⁴⁷ Н. Багабанди, *Үнэ цэнэтэй объектуудыг хувьчилж болно л доо*, Өдрийн Сонин, 1999.06.21.

⁴⁸ *Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль*, Ардын Эрх, 1993.06.08

⁴⁹ Н. Багабанди, *Монголын төр нүдтэй, чихтэй шүү*, Ардын Эрх, 1997.12.31

зуунд дэлхийг эзэгнэхийг хүсвэл бид болгоомжлох хэрэгтэй”⁵⁰ гэжээ. Н.Багабанди 2000 он хүртэлх хугацаанд Ерөнхийлөгчийн албыг хашиж байхдаа Монгол Улс Казахстан, Кувейт, Түрк, Япон, Герман, Хятад, Өмнөд Солонгостой харицаагаа хөгжүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн. Эдгээр харилцааг нарийвчлан авч үзвэл Япон, Хятад, Өмнөд Солонгос улсуудад салбараасаа шалтгаалж түлхүү анхаарсан бололтой.

Хувьчлал ба бүс нутгийн бодлого

1996 оны 6 дугаар сарын 30-ны сонгуулийн бараг судлагдаж тайлбарлагдалгүй үлдсэн нэг үр дүн бол АХ-ноос АНУ, Өрнөд Европыг баримжаалах хүсэл нилээд хөгжсөн улс төрчид эрх мэдэлд хүрсэн явдал байлаа. Энэ үзэгдэл дангаараа л Москва, Бээжин дэх улс төрийн хүрээнийхнийг түгшээж байв. Японы шинжээчдэд ч бас тайлбар шаардагдаж байв. Эдгээр болгоомжлол нь янз бүрийн шалтгаантай байсан бөгөөд зарим талаар тухайн улс орнуудын дотоодын байдал, тэдгээрийн эдийн засгийн болоод бүс нутгийн ашиг сонирхолтой холбоотой. Орос улсын цэрэг дайны чадавхиа алдаж байх үед өдийг хүртэл тайван байсан бүс нутагт цэрэг-стратегийн тэнцэл алдагдахаас эмээж байсан бол Хятад улс Өрнөдөөс Монголоор дамжуулан улс төрийн нөлөөгөө Шинжаан, Өвөр Монголын үндэсний цөөнх орших газар нутагт ихэсгэх нь хэмээн сэжиглэж байлаа. 1999 оноос “Америкийн дуу хоолой” нэвтрүүлэг Монголын FM 107 радиогоор цацагдаж эхэлсэн нь үүнийг баталж байгаа мэт байлаа. Орос, Хятад улсуудын аль аль нь Монголын нутгаар дамжуулан газрын хийн хоолой, эрчим хүчний шугам барихаар төлөвлөж байсан бөгөөд үүнд Япон, Солонгосын мөнгө ч урсах ёстой ажээ. Японы хувьд бүс нутгийн бодлого, ирээдүйн ашиг сонирхолоо хэрэгжүүлэхэд саад учирлаа гэж үзжээ.⁵¹

Нэг талаас Монгол дахь Америкийн болоод Европын ашиг сонирхол, нөгөө талаас Орос, Хятад, Японы ашиг сонирхлыг авч үзвэл Монгол Улс үндэсний, даяршлын, бүс нутгийн ашиг сонирхлын төвд оршиж буй нь тодорхой байна. МАХН-ын дарга Н.Энхбаяр хэлэхдээ: “Монгол дахь улс төрийн үйл явцыг бүх дэлхийн үйл явцын нэгэн хэсэг гэж үзэж байна”⁵² гэсэн байдаг. Дээрээс нь тэр болгон дурьдагддаггүй

⁵⁰ О. Дашбалбар, *Наранцацралт жижиг үндэстнийг аврах алхам хийсэн, Өдрийн Сонин*, 1999.07.22

⁵¹ U. B. Barkmann, *Die mongolisch-japanischen Beziehungen, (1996-1998) – Die Mongolei zwischen Globalisierung und Regionalisierung, aus Japan 1998/99 – Politik und Wirtschaft, Hrsg. M. Pohl, Institut für Asienkunde, Hamburg 1999, S.129-159.*

⁵² *Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хамтарсан мэдээгдэл, Өдрийн Сонин*, 1999.06.01.

Боловч чухал ач холбогдол бүхий хүчин зүйл бол дэлхий дээрх түүхий эдийн уламжлалт эх үүсвэрүүдийн нөөц шавхагдаж байгаа тул хэдхэн жилийн дараа нөөцөөр баялаг Монгол орныг шинээр үнэлэх шаардлага байхгүй тулгарна. Өмнөд Солонгосын шинжээчдийн мэдээлснээр Монгол Улс түүхий эдийн нөөцөөрөө ямар ч байсан дэлхийд 10-т ордог байна. АХ-ны Засгийн газрын хамгийн чухал ач холбогдолтой "Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр"-г Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 160 тоот шийдвэрээр баталж, 1999 оны 7, 8 дугаар саруудад төрийн өмчийн чухал ач холбогдолтой үйлдвэрүүдийг хувьчлахаар заасан нь Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Дэ Жун, Японы Ерөнхий сайд К.Обучи БНХАУ-ын Ерөнхийлөгч Жан Земин нар маш ойрхон дараалалтайгаар Монголын Ерөнхийлөгчид айлчлах дохио нь болсон болов уу. Н.Багабандийн зочдын хэлсэн үгнээс зэрэгцүүлэн хэлж судлах нь сонирхол татаж байна. Анх удаахад л ашиг сонирхол төстэй болохыг харж болно.

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Де Жун /Монгол Улс дахь анх удаагийн айлчлал 1999.05.30.- 06.01./:

Ким Дэ Жун: "Монгол нь дэлхийн байгалийн нөөц баялаг ихтэй арван том орны тоонд ордог. Манай Солонгос улс Монголын байгалийн нөөц баялагийг боловсруулах болон холбоо харилцаанаас эхлээд төрөл бүрийн дэд бүтцийн салбарт туслалцаа үзүүлснээр Монголын эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулж чадна".⁵³

Японы Ерөнхий сайд К.Обучи /Монгол Улсад хийсэн айлчлал 1999.07.10./:

К.Обучи: "Тодруулбал, манай Засгийн газар, Монголын талаас илүүтэй анхаарч хүсэлт гаргаж байсан хоёр орны хооронд хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийг байгуулах тухайд аль болох нааштай шийдэх талаас нь судалж байна. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулалтыг бодитойгоор дэмжихэд түүнийг хүлээн авч буй улс оронд бүрдсэн хөрөнгө оруулалтын орчин нөхцөл онцгой чухал үүрэгтэй бөгөөд Монголын тал энэ тухайд цаашид ч Ерөнхийлөгч Н.Багабанди К.Обучид хандан: "Япон улстай XXI зуунд иж бүрэн түншлэлийн хэмжээнд хамтран ажиллах нь манай төрийн бодлогын нэг тулгуур зарчим гэдгийг би дахин нотолж байна."⁵⁴

⁵³ Ким Дэ Жун: Хүн төрөлхтөн Монголчуудаар дамжуулан анх удаа дэлхийн түүхтэй болсон, Өдрийн сонин, 1999.06.01

⁵⁴ Ерөнхий сайд К. Обучи, Монголын ардчилсан өөрчлөлтийг цаашид ч дэмжихээ илэрхийлэв, Өдрийн Сонин 10.07.1999

БНХАУ-ын Ерөнхийлөгч Жан Земин /Монгол Улсад хийсэн айлчлал 1999.07.15.-16./

Жан Земин: "Монгол Улс мөн адил Хятад Улстай харилцах харилцааг их чухалчилж байдаг бөгөөд Хятад-Орос хоёр их хөрштэй тогтоосон харилцааг бүхэл бүтэн гадаад харилцааны тэргүүн байранд тавьж байсаар нэгэн удаа илэрхийлснийг бид мэдэж байна... Хоёр орхэы эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа нь харилцан нөхөх чанартай. Монгол Улс байгалийн арвин баялагтай. Түүний дотор зэс, төмөр, нефть бий. Хятад Монголын байдалд зохицсон техник, бүтээгдэхүүн байна... Үүний зэрэгцээгээр Монголын талаас хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, Хятадын хөрөнгө оруулалтын хууль ёсны эрх ашгийг баталгаажуулна гэж найдаж байна.⁵⁵

Японы Ерөнхий сайд К.Обучи, БНХАУ-ын Ерөнхийлөгч Жан Земиний⁵⁶ айлчлалуудыг ажиглахад айлчлалын түвшингийн ялгаанаас гадна, ач холбогдлыг өөрөө үнэлсэн болов уу гэмээр санагдаж байна. Улаанбаатар хотноо 1999 оны 6 дугаар сард болсон Хандивлагчдын 7 дугаар хуралдаанаар хандивлагч орнуудын нийт 320 сая ам. долларын тусламжийн хөрөнгөнөөс дангаар 115 сая ам. долларыг буюу нэг орон дангаар хандивласны хамгийн ихийг гаргасан билээ. Энэ утгаараа уг айлчлал хамгийн нааштай уур амьсгалд болно гэж бодмоор. Гэтэл К.Обучигийн айлчлалын талаарх мэдээ сэлт нь Жан Земиний айлчлалынхтай харьцуулбал хамаагүй хөндий маягтай болжээ. Үүгээр ч зогсохгүй Жан Земин, Н.Багабанди нарын хоорондын харьцаа зарим талаараа харилцан итгэлцэл /элгэмсэг байдал/ илүү байлаа гэж тодорхойлохоор байв. Жишээлбэл Н.Багабанди Хятадын төрийн зочинтойгоо Төв аймгийн Эрдэнэ сум руу, "хөдөө" явсан байна. Төрийн тэргүүнүүдийг Хятадын сэтгүүлчдээс гадна Монголын хоёрхон сэтгүүлч дагалдан явахыг зөвшөөрсөн байна. Жан Земиний үгийг Монголын хоёр сэтгүүлчдэд машинд товчилсон байдлаар орчуулж байсан гэдэг. Төрийн олон айлчлал давхацсан "99 оны гайхалтай" явдлын учрыг олохыг зорьсон нэгэн сэтгүүлчийн хэлснээр: "Тэдгээр улсын айлчлал нь магадгүй сүүлийн хоёр жилийн байдлаар уналтад ороод байсан Азийн эдийн засгийг сэргээх, шинээр түнш, экспортын шинэ зах зээл хайхтай холбоотой байсан болов уу. Гэхдээ нуулгүй хэлэхэд Монгол Улс эдийн

⁵⁵ БНХАУ-ын дарга Жан Земин Монголын хэвлэлд яоилцлага өглөө, Өдрийн Сонин, 14.07.1999

⁵⁶ Япон, Хятад Улс хоорондоо ялгаатай шалтгааны улмаас Монголын асуудлаар хүчтэй өрсөлдөгчид юм. Түүхэн байр сууринаас үзсэн ч Солонгос энд тийм ч онцгой үүрэг хүлээдэггүй.

засгийн эдгээр "аварга загаснуудын" хувьд хүрэхүйц зах зээл биш. Бид Японыг АНУ-ын дараа орох эдийн засгийн хоёр дахь хүчин, Өмнөд Солонгосыг дэлхий дээр 11-т орох эдийн засгийн хүч, Хятадыг 20 жилийн дараах дэлхийн эдийн засгийн хамгийн том хүчний хувьд авч үзэж болох юм. Энэ утгаараа ч манай орны эдийн засаг эдгээр эрч хүчтэй дипломат харилцаануудын хөдөлгүүр болж бүр чадахгүй. Монголын хамгийн том хоёр хөрш болох Орос, Хятадаас АНУ-тай харилцах харилцаа нь нарийн түвэгтэй болсоор байна. Косовогийн хямрал дээр дурьдсан хоёр гүрэн, АНУ-ын харилцаанд шууд бус замаар цохилт өгсөн. Хэрвээ Орос Улсад дэлхий дахины асуудал шийдвэрлэхэд саналын эрхгүй болохыг нь НАТО-гоос Югославид цохилт өгсөнөөр ойлгуулсан бол Хятадын Белград дахь Элчин Сайдын Яамыг бөмбөгдсөнийг Америкийн нууц албадын орчин үеийн хамгийн том алдаа хэмээн үзэж байна. Өрнөдийн ихэнх ажиглагчдын үзэж буйгаар Америкийн эсрэг чиглэсэн Москва, Бээжингийн холбооны тухай ярих боллоо. Нөгөө талаас Вашингтон болоод түүний холбоотнууд болоод Зүүн Ази, Зүүн Хойд Азид ижил ашиг сонирхолтой Өмнөд Солонгос, Япон нь Москва, Бээжингийн холбоотой тулгарлаа."⁵⁷ Энэ сэтгүүлчийн хөндөж байгаа дэлхийн хэмжээний улс төрийн хүчин зүйлс яах аргагүй оршиж байгаа бөгөөд, "шүүслэг хэсгүүдийг" хувьчлах холбоотой төгсгөлийн хэсгийг зөвхөн эрчимжүүлэх нөлөөтэй.

Төрийн тэргүүнүүдээс гадна эдийн засгийн төлөөлөгчид буюу Daewoo болоод Hyundai компаний удирдах зөвлөлийн тэргүүнүүд Монгол Улстай бауксит болоод бусад түүхий эдийг олборлоход туслахаа илэрхийллээ.⁵⁸ Өмнөд Солонгос, Япон, Хятадын аль аль нь хувьчлалын хүрээнд махны "шүүслэг хэсгээс" олж авахаар стратегийн хүчин зүйлийг харгалзан хөрөнгө оруулахыг эрмэлзэж байсан ч Монголын эдийн засгийн эрх зүйн зохицуулалт зарим талаар хэтэрхий эх газрын шинж чанарыг агуулсан тул болгоомжиллоо.

Жан Земиний айлчлалын дараахан МАХН-ын Удирдах Зөвлөл Ч.Олзвойг Мэдээлэл, гадаад харилцааны зөвлөхөөр томиллоо. Ч.Олзвой нь 1990-1994 онуудад БНХАУ дахь Монгол Улсын элчин сайдаар ажиллаж байсан бөгөөд Монголын гадаад бодлогын стратегийн

⁵⁷ Монголын цэцэглэж буй шинэ имидж, Үндэстэн, /1999/ № 7.

⁵⁸ Мицубиши Моторс Улаанбаатарт автосалон нээж, түүнийг Форд дагалаа. Тоёота, Мицубиши, Форд компаниуд зөвхөн Монголын автомашинны зах зээлд ийнхүү төлөөлөлтэй болж өрсөлдөх нь зах зээлийн худалдан авах чадвар сул тул үнэмшил муутай байна. Монголын эдийн засгийн хууль тогтоомж нь Монголыг Өмнөд Сибирь, Хятадын хойд хэсэгт үйл ажиллагаа явуулахад дөхөм болгож байна.

"толгойнуудын" нэг байсан нь эргэлзээгүй.⁵⁹ Энэ үед Ч. Олзвой болоод МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн дарга Л.Энэбиш нар Монгол-Хятадын цаашдын харилцаанд нэгэн чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн ойрын хүмүүс үзэж байлаа. Энэ хүмүүс хоёулаа таалал төгссөн билээ.

Дүгнэлт

МАХН нь 2000 оны парламентийн сонгуульд ялалт байгуулах нь өнөөгийн шинж тэмдгээс харахад бараг тодорхой болоод байна. МАХН засгийн эрхэнд гарснаар сүүлийн хэдэн жилийн туршид шинэ зүйл сурах, шинэчлэгдэх, нөхцөл байдалд өөрөө нийцүүлэх өндөр чадвартай бөгөөд энэ утгаараа Монголын нийгмийн бэрхшээлд нийгмийн бусад хүчнээс ойр байж чадсан нам засгийн эрхийг гартаа авна гэдэгт эргэлзэх зүйлгүй. Түүнтэй хамтаар хүлээн авах боломжгүй эргэлт бүр ухралт ирж магадгүй гэх ойлголтыг зарим хүмүүс илэрхийлж байсан. Гэхдээ ийм тодорхойлолт нотолгоо шаардаж байсан бөгөөд үүнээс хойших үйл явцаас харахад энэ нь хэрэгжээгүй билээ.

МАХН-ын 1996-2000 онуудад үзүүлсэн амжилт нь үндсэндээ дөрвөн хүчин зүйлд тулгуурлаж байсан юм. Үүнд нэгдүгээрт, Н.Энхбаяр болоод түүний баг намыг зөв зүйтэй удирдсан, хоёрдугаарт, намыг нэгдмэл болоод санаа нэгтэй байлгасан, гуравдугаарт, удирдлага болоод жирийн гишүүдийн хоорондын нэгдлийн чадавхийг гүнзгийрүүлсэн, дөрөвдүгээрт, намыг бүтэц болон хөтөлбөрийн хувьд шинэчлэх зорилгоор хийсэн алхамууд зэрэг болно. Удахгүй зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх намын удирдлагын хүрээний гишүүд нь өнөөдөр түүхийн туршлагыг санах нь зөв болов уу. Учир нь нийгмийн амьдралын хөгжлийн үр дагавраас зайлах боломжгүй байх тул Монголын өнөөгийн нийгэм улс төрийн хамгийн хүчирхэг хүчнээсээ татгалзах боломжгүй юм.

Мөн эргээд харахад бас нэгэн туршлагыг мартаж болохгүй. Намын удирдлага Монголын ирээдүй гагцхүү хоёр хөршдөө холбогдсоноор тодорхойлогдохгүй гэж үзжээ. МАХН нь үүгээрээ Коминтерны анзаараггүй байдлыг ашиглаж Герман руу гүүр барьж

⁵⁹ Олзвой, Чумбаагийн, 1949 онд төрсөн. 1973 онд Москвагийн Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийг гадаад худалдааны эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1983-1985 онуудад Москвагийн Дипломатуудын Академийг дүүргэсэн. Гадаад Харилцааны яамны газрын дарга, дэд сайд, 1990-1994 онд Монгол Улсаас БНХАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд.

эхэлсэн 20-иод онуудын ойлголтоо сэргээж байна. Өнөөдөр ч гэсэн Монгол Улс гадаад бодлогодоо Герман Улстай иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлэхийг хүсч байна. Үүнд зөрэгээр үнэлэгдэх шалтгаан мундахгүй. Монгол Улсын шилжилтийн үйл явц хэрэгжих үед Герман Улсын хувьд Монгол Улс нь урьдчилан тооцоолох боломжтой, ямар нэг ашиг хайгаагүй бөгөөд өөр нэгэн “гуравдахь хүчинтэй” харьцуулбал уг бүс нутагт геополитикийн тодорхой ашиг сонирхолгүй түншлэгч болохоо харуулсан нь үүний нэг жишээ биз ээ.